

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

*(Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар
хавсралтаар баталсан аргачлалд нийцүүлэн бэлтгэв.)*

2026 он

АГУУЛГА

НЭГ.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ	3
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ.....	3
ГУРАВ.ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ШАЛГАХ ХЭРЭГСЭЛ	4
3.1.Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал.....	4
3.2.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал.....	11
3.2.1.Хуулийн зорилго ойлгомжтой эсэх	11
3.2.2.Хуульд тусгасан нэр томъёо ойлгомжтой эсэх	13
3.2.3.Эрх зүйн хийдэл үүсгэж байгаа зохицуулалт	15
3.2.4.Товчлол хийсэн байдал	16
3.2.5.Хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлага	17
3.3.Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал	17
3.3.1.Хуулийн төслийн 6 ба 8-р зүйлийг үнэлсэн байдал.....	17
3.3.2.Хуулийн төслийн 14-р зүйлд заасан Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн системийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ	22
3.4.Практик хэрэгжих шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг байдал	24
3.4.1.Хуулийн төсөл дэх ус цаг уур, орчны мэдээллээр хангах үйлчилгээ	25
3.4.2.Мөнгөн тэтгэмж олгохтой холбогдсон зохицуулалт	26
3.4.3.Цалин хөлсийг нэмэгдүүлж олгохтой холбогдсон зохицуулалт	27
3.4.4.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй холбогдсон зохицуулалт	28
3.5.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал	29
3.5.1.Хуулийн төслийн доторх зүйл заалтын уялдаа холбоо.....	29
3.5.2.Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой уялдсан эсэх	32
Дөрөв.ДҮГНЭЛТ	38
4.1.Зорилгод хүрэх байдлын үнэлгээний дүгнэлт	38
4.2.Ойлгомжтой байдлын үнэлгээний дүгнэлт	39
4.3.Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээний дүгнэлт.....	39
4.4. Практикт хэрэгжих байдлын үнэлгээний дүгнэлт	40
4.5.Харилцан уялдааг үнэлсэн байдлын дүгнэлт.....	41
НОМ ЗҮЙ	43
Хавсралт 1	45
Хавсралт 2	56

Энэхүү тайланд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”¹-ын дагуу үнэлж, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан хүргэж байна.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь дараах 8 бүлгээс бүрдэх ба нийт 29 зүйлтэй. Хуулийн зорилтыг “хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон байна. Уг шинэчилсэн найруулгын төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

НЭГ.ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхээр дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонгов:

- Зорилгод хүрэх байдал,
- Практикт хэрэгжих боломж,
- Ойлгомжтой байдал,
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал,
- Харилцан уялдаа.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ

Дээрх шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэхээр дор дурдсан зохицуулалтуудыг сонгов:

- **Зорилгод хүрэх** байдлыг сонгохдоо хуулийн төслийн ус цаг уур, орчны хяналт шинжилгээг зохицуулсан 6, 7, 8 дугаар зүйлийг авч үнэлэв.
- **Практикт хэрэгжих** байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно. Үүний тулд төслийн 25 болон 27 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг авч үнэлэв.
- **Ойлгомжтой байдал** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана. Үүний тулд төслийн чухал суурь ойлголтыг тодорхойлсон нэр томъёог тайлбарласан 3 дугаар зүйлийг авч үнэлэв.
- **Хүлээн зөвшөөрөгдөх** байдал үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана. Үүний тулд хуулийн төслийн 6, 8 болон 14 дүгээр зүйлийг сонгон авч үнэлэв.
- **Харилцан уялдаа** шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн доторх болон бусад холбогдох хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг шалгав.

¹ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ГУРАВ.ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН ШАЛГАХ ХЭРЭГСЭЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтээр хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх зохицуулалт болон тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 6, 7, 8 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг үнэлнэ.	Үзэл баримтлалд туссан зорилгод болон хуулийн төслийн зорилтод хүрсэн эсэхийг үнэлнэ.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 25 болон 27-р зүйлийг зарим хэсэг, заалтыг авч үнэлнэ.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн 3-р зүйлээр зохицуулсан нэр томъёог үнэлнэ.	Хуулийн төслийн нэр томъёо нь хууль хэрэглээг хангасан эсэх, давхардал, зөрчил байгаа эсэх, бусад хуультай нийцэж байгаа эсэх, хэл зүй, найруулгын хувьд оновчтой томъёолсон эсэхийг шалгана.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 6, 8 болон 14-р зүйлийн зарим хэсэг, заалтыг үнэлнэ.	Хуулийн төслийн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа болон аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх гэсэн асуулгаар шалгана
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь үнэлнэ.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгана.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1.Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал

Хуулийн төслийн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээтэй 6 дугаар зүйл болон түүнтэй холбоотой бусад зүйл, хэсэг, заалтын хүрээнд зорилгод хүрэх байдлыг үнэлсэн байдлыг үнэлэв.

Уур амьсгалын өөрчлөлт 1800 оноос хойш хүний үйл ажиллагааны улмаас дэлхийн дундаж температур ойролцоогоор Цельсийн 1.2 хэмээр нэмэгдсэн бөгөөд энэхүү дулаарлын гуравны хоёроос илүү хувь нь 1975 оноос хойш тохиожээ. Дэлхийн дулаарал Цельсийн 1.5 хэмээс дээш гарах аваас олон тооны өөрчлөлт эргэлт

буцалтгүй буй болж, хүн төрөлхтний соёл иргэншилд маш ноцтой аюул учруулж болзошгүй талаар олон эрдэмтэд анхааруулж байна.²

Монгол орны уур амьсгал сүүлийн 70-аад жилд олон жилийн дунджаас 2,1 хэмээр дулаарсан нь дэлхийн дулаарлын дундаж хэмжээтэй харьцуулахад 3 дахин илүү дулаарсан байна. Тодруулбал, дэлхийн агаарын дундаж температур сүүлийн 120 жилд 0,84 градусаар ихэссэн бол манай оронд сүүлийн 70 жилд агаарын дундаж температур 2,25 градусаар дулаарчээ. Олон улсын судлаачид Монгол орон газар зүйн байршил, уур амьсгалын системийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг 10 орны нэг гэж тодорхойлжээ.

Манай улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 63 удаа тохиолддог байна. Харин сүүлийн 10 жилд дунджаар 99 удаа болж нэмэгдсэн байна.³

Энэ байдлаас харахад ус цаг уур, орчны шинжилгээ чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ чухал үүргийг гүйцэтгэх үндсэн бүтцийг хуулийн төсөлд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ /цаашид “улсын сүлжээ” гэх/-тай байхаар тусгасан ба ус, цаг уур, орчны төлөв байдлыг ажиглах, хэмжих, мэдээллээр хангах зорилго бүхий ажиглалтын станц, лаборатори, ажиглалт, хэмжилтийн цэгүүдээс бүрдэнэ (6.1) гэж заасан.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд⁴ “2025 оны 5 дугаар сарын байдлаар 300 сум, 18 тосгон, дүүрэгт цаг уурын өртөө, харуул ажиллаж байгаа, түүнчлэн ЦУОШГ-ын харьяанд Нислэгийн цаг уурын төв, Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори, Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн ажиллаж байна. Ус цаг, уурын салбарын үндсэн зохион байгуулалт, ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээ болсон ч цаг уурын өртөөний тоо олон улсын стандартад зөвлөснөөс бага байгаа тул ажиглалтын өгөгдлийн орон зайн хүртээмжийг хязгаарлаж, уур амьсгалын үйлчилгээ, эрт сэрэмжлүүлгийн чанарт нөлөөлөх эрсдэлтэй гэж дүгнэсэн.

Дэлхийн цаг уурын байгууллага (WMO)-ын WMO-No.54 (CIMO Guide)-д зааснаар ажиглалтын сүлжээний нягтаршлыг бүс нутгийн онцлогт нийцүүлэн тодорхойлох бөгөөд суурин ажиглалтын станцуудын хоорондын зай, тархалт нь тодорхой доод шаардлагыг хангаж байж уур амьсгалын төлөөлөх чадвар (representativeness) болон мэдээллийн чанарыг хангана гэж гишүүн орнууддаа зөвлөдөг. Сүлжээний нягтаршил хангалтгүй байх нь:

- орон зайн өгөгдлийн тасалдал үүсгэх,
- эрс тэс цаг агаарын үзэгдлийг бүрэн барихгүй байх,
- эрт сэрэмжлүүлгийн системийн нарийвчлалыг бууруулах,
- уур амьсгалын үйлчилгээ (climate services)-ний чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Дараах хүснэгтэд Монгол Улс, БНСУ, БНХАУ болон Япон улсын цаг уурын ажиглалтын үндсэн сүлжээний хэмжээ, газар нутгийн харьцуулалт, станцын нягтралыг нэгтгэн үзүүлэв.

² Уур амьсгалын өөрчлөлтийн толь бичиг: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх өдөр тутмын гарын авлага | United Nations Development Programme

³ Уур амьсгалын өөрчлөлт дэлхий дахинд хэрхэн нөлөөлж байна вэ? Онцгой байдлын ерөнхий газар, <https://nema.gov.mn/>

⁴ 1997.11.13-ны өдөр баталсан хүчин төгөлдөр мөрдөж байгаа Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025 он

Улс	Газар нутаг	Хүн ам (ойролцоогоор)	Үндсэн/автомат станц	Дундаж нягтрал (ойролцоогоор)	Онцлог
Монгол Улс	1.56 сая км ²	3.5 сая	137 үндсэн станц, 181 харуул	100–200 км+ (зарим бүсэд түүнээс их)	Маш сийрэг сүлжээ, өргөн нутаг + бага хүн ам, Ус цаг уур, орчны шинжилгээний газар хариуцдаг.
БНСолонгос улс	100,210 км ²	51 сая	97 үндсэн станц + хэдэн зуун AWS	30–40 км (үндсэн станц), AWS 10–13 км хүртэл	Өндөр нягтралтай, гамшгийн эрт сэрэмжлүүлэгт төвлөрч ажилладаг. Солонгосын ус цаг уурын захиргаа (Korea Meteorological Administration) хариуцдаг.
БНХАУ	9.6 сая км ²	1.41 тэрбум	76,000+ автомат станц	5–50 км (бүсээс хамаарна)	Дэлхийн хамгийн өргөн хүрээтэй автомат сүлжээний нэг. Хятадын цаг уурын захиргаа (China Meteorological Administration) хариуцдаг.
Япон улс	377,975 км ²	125 сая	1,300 AMeDAS станц	17 дундаж км	Маш өндөр нягтралтай автомат сүлжээ, гамшгийн мониторинг өндөр. Японы ус цаг уурын агентлаг (Japan Meteorological Agency) хариуцдаг.

Япон Улсын жишээ

Японы цаг уурын агентлаг (JMA) нь улсын хэмжээнд өндөр нягтралтай ажиглалтын сүлжээ ажиллуулдаг.

- Суурин цаг уурын 156 орчим мэргэжлийн ажиглалтын станц
- Үүнээс гадна 1,200 гаруй автомат цаг уурын станц (AMeDAS)
- Улсын хэмжээнд нийтдээ ойролцоогоор 1,300 орчим гадаргын ажиглалтын цэг ажиллаж байна.

Эдгээр станцууд нь дунджаар ойролцоогоор 17 км-ийн торон зайтай байрлаж, хур тунадас, температур, салхи зэрэг үндсэн үзүүлэлтийг өндөр давтамжтайгаар хэмждэг.⁵ Ийм нягт сүлжээ нь богино хугацааны хүчтэй аадар, хар салхи, үер зэрэг гамшгийг өндөр нарийвчлалтайгаар хянах, 0–6 цагийн эрт сэрэмжлүүлгийн системийн үр ашгийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлдэг байна.

⁵ Japan Meteorological Agency, <https://www.jma.go.jp/jma/en/Activities/observations>

БНСУ-ын жишээ

БНСУ-ын Солонгосын ус цаг уурын захиргаа (Korea Meteorological Administration/KMA) нь харьцангуй жижиг нутаг дэвсгэрт маш өндөр нягтралтай ажиглалтын сүлжээ ажиллуулдаг. 97 үндсэн цаг уурын станцтай ба нягтрал буюу хоорондын зай ойролцоогоор 30–40 км ба автомат цаг уурын ажиглалтын (AWS) хэдэн зуун станцын хоорондын зай зарим бүсэд 10–13 км байдаг, хот суурин, далайн эрэг, уулын бүсэд илүү нягт сүлжээ байгуулсан байдаг.

Энэ өндөр нягтралтай сүлжээ нь аадар бороо, хар салхи, үер зэрэг аюулт үзэгдлийг богино хугацаанд илрүүлэх, өндөр нарийвчлалтай богино хугацааны прогноз боловсруулах, нисэх, далайн тээвэр, гамшгийн эрсдэлийн удирдлагыг шуурхай мэдээллээр хангах, уур амьсгалын өөрчлөлтийн мониторинг хийхэд чухал ач холбогдолтой байдаг.

БНХАУ-ын жишээ

БНХАУ-ын ус цаг уурын сүлжээ нь 76,000 гаруй автомат станцтай ба бүх нутаг дэвсгэрийг хамарсан маш өндөр нягтралтай сүлжээтэй. Цаг агаар бус уур амьсгал, гамшгийн менежмент, хөдөө аж ахуй, байгаль орчны хяналт зэрэг олон чиг үүргийг нэгтгэсэн “нэгдсэн ажиглалтын систем” юм.

Тус улсын Ус, цаг уурын алба болох (China Meteorological Administration/CMA) нь дэлхийн хамгийн том, хамгийн нягтрал Нягтрал нь орон нутаг бүрт (ялангуяа суурьшлын бүсүүдэд) 10–20 км орчим торлог нягтралтай сүлжээний бүтэцтэй ба зарим бүсэд тухайлбал хөдөө аж ахуй, уул уурхай, CMA-ийн цаг уурын станцууд цаг агаарын ажиглалт, урьдчилсан мэдээ, онц аюултай үзэгдлийн эрт сэрэмжлүүлэг, уур амьсгалын судалгаа, хөдөө аж ахуй, ус, эрчим хүчний дэмжлэг, агаарын бохирдол, байгаль орчны хяналт болон олон улсад мэдээлэл солилцох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын нөхцөл байдал

Монгол Улсын хувьд ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний сүлжээ нь өргөн уудам газар нутаг, хүн амын сийрэг байршлаас шалтгаалан харьцангуй бага нягтаршилтай байна. Суурин цаг уурын ойролцоогоор 310 орчим үндсэн станц, ихэнх нь 50–100 км ба түүнээс дээш зайтай байрладаг. Алслагдсан говь, өндөр уулын бүсэд ажиглалтын орон зайн хоосон бүс (data gap) үүсэх тохиолдол түгээмэл. Ийм байдал нь орон нутгийн эрс тэс үзэгдлийг бүрэн илрүүлэх боломж хязгаарлагдмал, богино хугацааны эрт сэрэмжлүүлгийн нарийвчлал буурах эрсдэлтэй, уур амьсгалын бүсчилсэн үнэлгээний тодорхой бус байдал нэмэгдэх сөрөг үр дагавартай.

Тиймээс WMO CIMO Guide-ийн санал болгосон сүлжээний доод нягтаршлын шаардлагатай бүрэн нийцэхгүй, түүнчлэн дээр дурдсан улсуудтай харьцуулахад харьцангуй доогуур байгаа нь харагдаж байна.

Төсөлд Төрөөс ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын үйлчилгээний инновац, судалгаа, дэвшилтэт технологи хөгжүүлэх үйл ажиллагаа болон хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ (6.5) гэж заасан. Хувийн хэвшлийн оролцоог бий болгосноор сүлжээний станцуудыг нягтрал нэмэгдэхэд тодорхой хувь нэмэр оруулахаар харагдаж байна.

Түүнчлэн, улсын сүлжээний 10 жилийн хугацаатай ерөнхий төлөвлөгөөтэй байх, тус төлөвлөгөөнд “улсын сүлжээн дэх станцын нягтрал, тоо хэмжээ, ангилал, байршил, төлөвлөлтийн зураг, станцын жагсаалт (7.2.4)-ыг тусгаж, байгуулахаар зохицуулсан байгаа нь шинэчлэл гэж үзэж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд 1980-аад оны сүүлээс хойш Монгол орны уур амьсгал эрчимтэй өөрчлөгдөж, байгалийн гамшигт үзэгдлийн (ган, зуд, цөлжилт, мөсөн гол хайлах г.м) давтамж нэмэгдсэн тул уур амьсгалын өөрчлөлтийн явц, түүний сөрөг үр дагавар, нөлөөллийг тасралтгүй ажиглаж хянах, болзошгүй аюул, эрсдэлийг судлан тогтоох, байгалийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт гаргах, холбогдох бодлого, хууль эрх зүйн орчныг оновчтой бүрдүүлэх шаардлага тулгарч байгааг талаар практик шаардлагад өргөн утгаараа нийцэж байна.

Мөн хуулийн төсөлд Улсын сүлжээний станцыг 8.2 дахь заалтад цаг уурын, ус судлалын, орчны хяналт шинжилгээний, хөдөө аж ахуйн цаг уурын, дээд агаар мандлын, цаг уурын радарын, мал аж ахуйн цаг уурын, нарны цацраг судлалын болон тусгай зориулалтын бусад гэсэн 9 төрөлтэй байхаар тусгажээ.

Хуулийн төслийн 8.2-т “улсын сүлжээний станц”-ыг 9 төрөлтэй байхаар ангилсан нь олон улсын жишигтэй нийцэж байгаа бөгөөд Япон, БНСУ, БНХАУ-ын ус цаг уурын байгууллагууд мөн адил төрөлжсөн ажиглалт, хяналтын сүлжээтэй ажиллаж байгааг дараах байдлаар харьцуулан харуулав.

Монгол Улсын хуулийн төсөлд тусгасан улсын сүлжээний станцын төрөл	Япон Улсад хэрэглэж буй ижил төрлийн станц	БНСУ-д хэрэглэж буй ижил төрлийн станц	БНХАУ-д хэрэглэж буй ижил төрлийн станц
Цаг уурын станц	Гадаргын цаг уурын ажиглалтын станц, автомат цаг уурын станц (AMeDAS)	Гадаргын цаг уурын станц, автомат ажиглалтын станц (AWS)	Үндэсний гадаргын цаг уурын станц
Ус судлалын станц	Гол мөрөн, хур тунадасны ус судлалын ажиглалтын станц	Усны түвшин, үерийн хяналтын станц	Ус судлал, гол мөрний мониторингийн станц
Орчны хяналт шинжилгээний станц	Агаарын чанар, хүчиллэг бороо, уур амьсгалын мониторингийн станц	Орчны болон агаарын чанарын хяналтын станц	Экологийн болон атмосферийн орчны мониторингийн станц
Хөдөө аж ахуйн цаг уурын станц	Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын станц	Агро-цаг уурын үйлчилгээний станц	Хөдөө аж ахуйн цаг уурын станц
Дээд агаар мандлын станц	Радиозондын болон дээд агаарын ажиглалтын станц	Дээд агаарын тандалтын станц	Дээд агаар мандлын цаг уурын станц
Цаг уурын радарын станц	Доплер цаг уурын радарын сүлжээ	Цаг уурын радарын ажиглалтын сүлжээ	CINRAD үндэсний цаг уурын радарын сүлжээ

Мал аж ахуйн цаг уурын станц	Бэлчээр, мал аж ахуйн эрсдэлийн мониторингийн цэг	Мал аж ахуйн цаг уурын зөвлөмжийн систем	Бэлчээр, мал аж ахуйн цаг уурын үйлчилгээний станц
Нарны цацраг судлалын станц	Нарны цацраг хэмжилтийн станц	Нарны цацрагийн мониторингийн станц	Нарны болон атмосферийн цацраг судлалын станц
Тусгай зориулалтын бусад станц	Далайн, нисэхийн, галт уул, цунамигийн ажиглалтын станц	Далайн болон нисэхийн тусгай станц	Цөлжилт, өндөрлөг, далайн болон нисэхийн тусгай станц

Мөн эдгээр улсын тогтолцооны онцлогийг дараах байдлаар дүгнэж болно:

Япон Улс

Японы ус цаг уурын агентлаг (Japan Meteorological Agency) нь дэлхийн хамгийн өндөр нягтралтай ажиглалтын сүлжээний нэгтэй бөгөөд

- АМеDAS автомат станцын үндэсний сүлжээтэй;
- Далайн, нисэхийн, галт уулын, газар хөдлөлтийн болон цунамигийн ажиглалтыг нэгтгэн ажиллуулдаг;
- Дээд агаар мандал, радарын олон шатлалт системтэй.

Японд станцын төрөлжилт нь гамшгийн эрсдэлийг бууруулах бодлоготой шууд холбоотой байдаг.

БНСУ

Солонгосын ус цаг уурын захиргаа нь:

- автомат станцын өндөр нягтралтай AWS систем;
- уур амьсгал, агаарын чанар, хөдөө аж ахуйн эрсдэлийн нэгдсэн мониторинг;
- хиймэл дагуул, радарын төвлөрсөн удирдлагын тогтолцоотой.

Солонгосын хууль, дүрэмд ажиглалтын төрөл тус бүрийн техникийн стандарт, өгөгдлийн нэгдмэл байдлыг нарийвчлан зохицуулдаг.

БНХАУ

Хятадын ус цаг уурын захиргаа нь дэлхийн хамгийн том сүлжээний нэг бөгөөд үндэсний, бүсийн, орон нутгийн шаталсан бүтэцтэй байдаг ба

- хөдөө аж ахуй, цөлжилт, бэлчээр, элсжилт, өндөрлөг газрын тусгай мониторингийн станцтай;
- цаг уурын радарын CINRAD үндэсний системтэй.

Хятадад “экологийн болон хөдөө аж ахуйн цаг уур” нь тусдаа чиглэл болон хөгжсөн нь монголын мал аж ахуйн цаг уурын станцын зохицуулалттай ойролцоо юм.

Иймээс Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд улсын сүлжээний станцыг төрөлжүүлэн ангилсан нь олон улсын жишигт нийцсэн байгаа тул гамшгийн эрсдэлийн удирдлага, хөдөө аж ахуй, усны нөөц, орчны мониторингийг нарийвчлах, өгөгдлийн чанар, салбар хоорондын уялдаа, эрт

сэрэмжлүүлэх чадавхыг сайжруулах талаарх төслийн Үзэл баримтлалын хууль зүйн болон практик шаардлагыг хангаж байна гэж дүгнэв.

Ус цаг уурын улсын сүлжээний 10 жилийн ерөнхий төлөвлөгөөтэй байх, энэ төлөвлөгөөнд улсын сүлжээн дэх станцын нягтрал, тоо хэмжээ, ангилал, байршил, төлөвлөлтийн зураг, станцын жагсаалт (7.2.4) болон станцийн төрлүүдийг шинээр тус тус тодорхойлж (8.2) Ус цаг уурын олон улсын байгууллага болон бусад улсын жишигт нийцсэн зохицуулалт болжээ. Ингэснээр, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хүрээ, нарийвчлал, хүртээмж нэмэгдэх ба дараах эдийн засаг, нийгмийн үр нөлөө үзүүлнэ.

Монгол орны уур амьсгал сүүлийн 80 жилд мэдэгдэхүйц дулаарч, гадаргын температур 2.25°C-аар нэмэгдэж, дэлхийн дулаарлын дундаж үзүүлэлтээс давсан. Ган, зуд, ой хээрийн түймэр, цасан шуурга, үер, хэт хүйтэн зэрэг нь улс орны хэмжээнд томоохон хэмжээний гамшигт тооцогдож байна. Эдгээр гамшгийн 81 орчим хувийг хүчтэй салхи, бороо, аянга цахилгаан эзэлж байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд байгалийн гамшгийн давтамж хоёр дахин нэмэгдсэн. Жилд учрах хохирлын хэмжээ дунджаар 50-70 тэрбум төгрөг байна. Энэ зууны дунд үе гэхэд малын хорогдол одоогийнхтой харьцуулахад 50 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа бол энэ зууны эцэс гэхэд хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байна.⁶ 2015-2021 онд байгалийн аюулт үзэгдлийн тоо 2.9 дахин нэмэгдэж, 7 жилийн хугацаанд нийт 394.6 тэрбум төгрөгийн хохирол (КОВИД-19 цар тахлыг оруулахгүйгээр) учирсан.⁷ Түүнчлэн 2001-2002 онд 2.9 сая мал, 2009-2010 онд 10.3 сая мал хоргодсон нь нийт малын 23.4 хувийг эзэлж байв.⁸ Гамшиг тохиолдсон тохиолдолд 24 цагийн дотор эрт сэрэмжлүүлэг өгснөөр учрах хохирлыг 30%-иар бууруулах боломжтой.⁹

Тиймээс Ус цаг уурын хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ус цаг уурын улсын сүлжээ (6.1), түүний төрөл (8.3), 10 жилийн хугацаатай төлөвлөгөөтэй байх (7.3), улсын сүлжээн дэх станцын нягтрал, тоо хэмжээ, ангилал, байршил, төлөвлөлтийн зураг, станцын жагсаалт, станц тус бүрийн ажиглалтын хөтөлбөр (7.2.4), улсын сүлжээний ажиглалтын станцыг ерөнхий төлөвлөгөөний дагуу байгуулах (8.3) зэрэг харилцан уялдаатай зохицуулалтуудыг шинээр болон шинэчлэн тусгасан байна. Энэ шинэчлэл нь хуулийн төслийн зорилтод туссан "...хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээдийг хангах..." зорилгыг хангахад чиглэгдсэн байна.

Дүгнэвэл, аюулт үзэгдлийн улмаас учирч болох хохирлоос урдчилан сэргийлэх мэдээллийг цаг тухайд хүргэх төрийн үйлчилгээ, түүний хүртээмж, нөхцөл сайжирч, гамшиг, аюулт үзэгдлээс учирч болох хүн, мал, эд хөрөнгийг тодорхой хувиар хамгаалах боломж нэмэгдэх эдийн засаг, нийгмийн үр нөлөө үзүүлнэ. Нөгөө талаас хүн, хуулийн этгээд цаг уурын урьдчилсан болон бодит мэдээллийг цаг тухайд нь авах эрх зүйн орчин сайжирснаар ахуй, амьдрал, аж ахуйгаа хөтлөхөд нэмэр тус болж байгаа байдал улам сайжирна.

⁶ Гамшиг, уур амьсгалын эрсдэлийг удирдах чадавхын үнэлгээ, 2024, [Mongolia CD Report-Mongolian.pdf](#)

⁷ Гамшиг, уур амьсгалын эрсдэлийг удирдах чадавхын үнэлгээ, 2024, [Mongolia CD Report-Mongolian.pdf](#)

⁸ Гамшиг, уур амьсгалын эрсдэлийг удирдах чадавхын үнэлгээ, 2024, [Mongolia CD Report-Mongolian.pdf](#)

⁹ "Бүх хүнд эрт сэрэмжлүүлэг" (EW4All), 2023, ДУАБ, <https://visionias.in/current-affairs>

Гэхдээ хуулийн төслийн ойлгомжтой байдал, практик хэрэгжих байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан уялдааг үнэлсэн үнэлгээг харгалзан үзэж сайжруулах шаардлагатайг онцлон тэмдэглэв.

3.2.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал

Тус шалгуур үзүүлэлтээр төсөлд хэрэглэсэн нэр томьёо, тухайн төсөл хэл зүй, найруулгын шаардлага хангасан эсэх, үг сонголтын хувьд оновчтой, ойлгомжтой эсэх, ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэх, логик дараалалтай боловсруулагдсан эсэх, тухайн зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай бичигдсэн эсэхийг шалгаж үнэлнэ.

3.2.1.Хуулийн зорилго ойлгомжтой эсэх

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” ерөнхий зорилгыг тусгажээ. Эцсийн дүндээ энэ хууль хэрэгжилтийн явцад зорилгодоо хүрсэн эсэхийг хэмжигдэхүйц, бодитой, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхой харьцуулан үнэлэх боломжтой байх ёстой.

“Ойлгомжтой байдал” шалгуур хангаагүй хэм хэмжээ, санал

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн холбогдох хэсэг	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль/Шинэчилсэн найруулга/-ын төслийн холбогдох хэсэг
1 дүгээр зүйл.Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Дүгнэлт: Хуулийн зорилт нь мэдээллээр хангахад чиглэгдсэн	Дүгнэлт: 1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээг явуулах 2.мэдээ, мэдээллээр хангахад чиглэгдсэн

“Хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зорилгын хүрээнд дараах зохицуулалт байна.

- төслийн 6.5 дахь хэсэгт “Төрөөс ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын үйлчилгээний инновац, судалгаа, дэвшилтэт технологи хөгжүүлэх үйл ажиллагаа болон хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.”

- төслийн 9.4 дахь хэсэгт “Автоматжуулсан багаж, систем, дижитал болон зайнаас тандах технологи, хиймэл оюун ухаанд суурилсан арга, аргачлалыг нэвтрүүлэх, нутагшуулах замаар хүний оролцооны алдааг бууруулах, өгөгдлийн чанар,

хүртээмжийг сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор олон улсын стандарт болон сүлжээтэй нийцүүлэн хөгжүүлнэ.”

- төслийн 17.8 дахь хэсэгт “Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг байгаль орчин, нийгэм-эдийн засгийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, тодорхой салбарын үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой бүс нутагт, тодорхой хугацаанд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хэрэгжүүлж болно.”

-төслийн 21.1.2 “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэвийн, тасралтгүй, байнгын үйл ажиллагааг дэмжиж, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтанд шаардагдах төсвийг батлах хэрэгжилтэнд хяналт тавих”

-төслийн 21.1.3 дахь хэсэгт “Орон нутгийн онцлог, байгаль ус цаг уур, орчны аюултай үзэгдлээс эрт сэрэмжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх”

-төслийн 11.8 дахь хэсэгт “ Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь нийгэм эдийн засгийн салбар, хүн ам, эд хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг тусгаж, нөлөөлөлд суурилсан урьдчилан мэдээ болон сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг агуулсан байж болно.”

Хэдийгээр дээр дурдсанчлан дэмжлэг үзүүлнэ гэж ерөнхий заасан боловч нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлсэн гэдгийг ямар шалгуураар үнэлэх вэ гэдэг нь тодорхойгүй байна.

Мөн “хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах” зорилгын хүрээнд хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангасан гэдгийг тоон болон чанарын ямар шалгуураар үнэлэх, уг эрхийг хангагдсан гэдгийг бодитой үнэлэх боломжтой эсэх нь эргэлзээ төрүүлж байна.

-Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн зорилт нь **ус цаг уур, орчны** мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахад чиглэж байсан бол төслийн зорилт нь **ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тасралтгүй явуулахаас гадна шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хангахад чиглэсэн байх бөгөөд энэ хуулийн нэртэй, үйлчлэх хүрээтэйгээ уялджээ.**

Монгол хэлний тайлбар тольд “мэдээ” гэдгийг ямар нэг зүйлийн талаар сонсгох, дамжуулах¹⁰ гэсэн утгаар, “мэдээлэл” гэдэг нь ямар нэг үйл баримтын талаар амаар болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх үйл явц, мэдээ дамжуулах, түгээх¹¹ гэсэн утгаар, “мэдээ мэдээлэл” гэсэн хоршоо үг нь олон түмэнд хүргэх, сонсгох үйл хэргийн товч, тойм гэсэн утгаар, “мэдээлэх” гэдэг нь мэдээлэл цацах, тодорхой болгон нийтлэх гэсэн утгаар тус тус тайлбарлажээ.

Эндээс үзэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээд зорилтыг хэрхэн хэмжих вэ? хэрвээ хүн, хуулийн этгээд шинжлэх ухааны үндэслэлгүй мэдээ, мэдээл гэдэгт юуг ойлгох вэ? хүн, хуулийн этгээд хэрхэн яаж ялган салгах вэ гэсэн асуулт гарч ирнэ. Хуулийн хэрэгжилтийн үнэлэхэд шинжлэх ухааны үндэслэлгүй мэдээ, мэдээлэл хүргэсэн гэдгийг ямар шалгуураар тогтоох вэ? энэ хуулийн 12.4-т заасан баталгаажуулаагүй мэдээ, мэдээллийг ойлгох уу? Эсхүл энэ хуулийн 27.9-д заасан баталгаажуулаагүй багаж, тоног төхөөрөмжийн мэдээ, мэдээллээр үйлчигээ үзүүлснийг ойлгох уу? Гэсэн асуулт гарч ирнэ.

¹⁰ Монгол хэлний тайлбар толь.УБ хот.2014 он, 731 дэх тал

¹¹ Монгол хэлний тайлбар толь.УБ хот.2014 он, 732 дахь тал

3.Төслийн 1.1-д ус цаг уур, орчны хяналт шинжилгээг явуулах гэж заасан атлаа төслийн 44.1.17-д ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 6.3-т хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх, 17.6 дахь хэсэг, 24.1.3-т орчны хяналт шинжилгээ хийх, 24.1.3-т орчны хяналт шинжилгээ хийх, 24.1.6-д ус цаг уур, орчны хяналт шинжилгээний судалгаа, шинжилгээний ажил хийх гэж тусгажээ.

Мөн төслийн 4.1.5, 6.5-т ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, 19.1.3, 21.1.2, 24.1.13 -т ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаа, 8.5.4 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажиглалт, хэмжилт гэх мэтчилэн өөр өөр үг хэллэг хэрэглэжээ.

Дээр дурдсанчлан хуулийн төсөлд туссан мэргэжлийн үг хэллэгийг тухайн салбарын мэргэжилтнүүд ойлгох хэдий ч хүн, хуулийн этгээд ойлгохгүй байх нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлнө гэж үзэж байна. Хяналт шинжилгээ гэж юуг ойлгох, хянах, магадлах, судлах, шинжлэх, дараа нь яах вэ? гэдэг нь тодорхойгүй.

Иймд хуулийн төсөлд хэрэглэсэн үг хэллэгийг жигдлэх, ялгаатай ойлголтыг мөн ойлгомжтой байдлаар томъёолох шаардлагатай байна.

3.2.2.Хуульд тусгасан нэр томъёо ойлгомжтой эсэх

3.2.2.1.Хүндрэл учруулж болзошгүй зохицуулалтууд

Хуулийн төсөлд тусгасан дараах нэр томъёонууд ойлгомжтой байгаагаас хуулийг хэрэглэхэд хүндрэл учруулахаар байна. Үүнд:

1/Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 6.1-д “ус цаг уур” гэж таслалгүйгээр тодорхойлсон атлаа төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “ус, цаг уур” гэж, төслийн гуравдугаар бүлгийн гарчигт “ус, цаг уур” гэж таслалтайгаар, 4.15-д “усан мандал” гэж устай холбоотой шинжлэх ухааны үг хэллэгийг 3 янзаар хэрэглэсэн нь төөрөгдөлд оруулж байна.

“Ус цаг уур” гэсэн шинжлэх ухааны үг хэллэгийг иргэд, хуулийн этгээд мэдэж хэрэгжүүлэхээс илүүтэйгээр “цаг агаар” гэдэг ойлголтыг мэдэх нь чухал гэж үзэж байна. Иймд төслийн 4.1.1-д заасан “ус цаг уур” гэсэн нэр томъёог хасах.

2/Төслийн 4.1.19-д “шинжилгээний талбай” гэж ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалтаар сонгон авч төхөөрөмжилсөн, хашаалсан болон өөр бусад байдлаар тэмдэглэж, заагласан орон зайг ойлгоно гэж, 10.1-д “ Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх шинжилгээний талбай нь тусгайлан сонгон авч, төхөөрөмжилсөн, заагласан газар байна” гэж заажээ.

Ийнхүү “шинжилгээний талбай” гэсэн ойлголтыг сонгон авч төхөөрөмжилсөн “орон зай” болон “газар” гэж өөр өөрөөр томъёолсон нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2-т заасан “нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх” гэсэн шаардлагатай нийцэхгүй байна.

Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "усны нөөц" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг ойлгоно гэж газартай холбож тайлбарласан байна.

Иймд “шинжилгээний талбай” гэсэн ойлголтыг газар гэсэн ойлголттой уялдуулан тодорхойлох

Түүнчлэн хуулийн хэрэгжилтийн явцад “шинжилгээний талбай” гэсэн ойлголтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

3.2.2.2.Төсөлд тусгасан боловч зохицуулалтад хэрэглэгдээгүй нэр томьёо

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “цаг уур” гэж дэлхийн агаар мандлыг судалдаг шинжлэх ухааны салбарыг гэж, 4.1.4-т “ус судлал” гэж гол, мөрөн, горхи, булаг, шанд, хуурай сайр, мөстөл, мөсөн гол, нуур гэх зэрэг гадаргын усны хувьсал, өөрчлөлтийг судалдаг ухааныг гэж, 4.1.8-д “урьдчилсан мэдээ” гэж ус цаг уур, орчны төлөв байдал, хувьсал, өөрчлөлтийн үйл явцыг хэдэн цаг, хоног, сар, улирлын өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан тооцоолж гаргасан мэдээллийг гэж, 4.1.14-т “уур амьсгалын өөрчлөлт” гэж байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр уур амьсгалд урт хугацаанд гарч буй хэлбэлзлийг гэж, 4.1.15-д “урт хугацааны урьдчилсан төлөв” гэж сар болон түүнээс дээш хугацааны уур амьсгалын төлөв байдлыг урьдчилан тодорхойлж гаргасан мэдээллийг гэж, 4.1.20-т “уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хувилбар” гэж нийгэм-эдийн засгийн үйл ажиллагаа, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлт, далайн түвшний өсөлтийн хоорондын харилцан хамаарал дээр үндэслэсэн уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй таамаглалыг гэж, 4.1.21-т “уур амьсгалын стандарт норм” гэж ус цаг уурын үзүүлэлтүүдийн гучин жилийн дундаж утгыг гэж, 4.1.22-т Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ” гэж аюул, өртөмхий байдал, эмзэг байдлын мэдээлэлд үндэслэн ус цаг уур, орчны аюулын нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан таамаглаж, авах арга хэмжээний зөвлөмжийг агуулсан мэдээг гэж ойлгоно гэж тодорхойлсон боловч эдгээр нэр томьёотой холбоотой хэн нэгэнд эрх олгосон, үүрэг болгосон, зөвшөөрсөн хэм хэмжээ хуулийн төсөлд тусгагдаагүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт нэр томьёо нь олон утгатай бол, эсхүл өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол, шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол нэр томьёоны тайлбар хийхээр хуульчилсан байна.

Тухайн салбарын мэргэжилтнүүдийн мэдвэл зохих мэргэжлийн нэр томьёог хуулиар биш нэр томьёоны тайлбарын стандарт, эсхүл салбарын нэр томьёоны толь гаргах замаар шийдвэрлэх нь зүйтэй.

Иймд Төслийн 4.1.3-т заасан “цаг уур”, 4.1.4-т заасан “ус судлал” гэсэн нэр томьёо нь салбарын мэргэжилтнүүдийн мэдвэл зохих нэр томьёо, 4.1.15-д заасан “урт хугацааны урьдчилсан төлөв” гэсэн ойлголт нь бусад мэдээллээс зөвхөн хугацаагаар ялгагдаж байгаа бөгөөд агуулгын хувьд 4.1.8-д заасан “урьдчилсан мэдээ” гэсэн ойлголттой давхацсан, 4.1.14-т заасан “уур амьсгалын өөрчлөлт”, 4.1.20-т заасан “уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хувилбар”, 4.1.21-т заасан “уур амьсгалын стандарт норм” гэсэн ойлголтууд энэ хуулийн зохицуулалтын хүрээнд хамаарахгүй, 4.1.22-т заасан “нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ” гэсэн ойлголт нь хэм хэмжээ агуулсан, тунхаглалын шинжтэй тусгагдсан мэргэжлийн нэр томьёонуудыг хуулийн төслөөс хасах.

3.2.2.3.Олон янзаар хэрэглэсэн нэр томьёо

-Төслийн 4.1.17-д “станц” гэж ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн байгууллагын бүтцийн нэгжийг, 4.1.18-д “ажиглалтын станц ” гэж ажиглалт, хэмжилт хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж, байгууламж, талбайн цогцыг ойлгоно гэж тус тус заасан. Гэвч төсөлд станц /4.1.117, 8.6/, улсын сүлжээн дэх станц/7.2.4./, улсын сүлжээнд хамаарах станц /8.4, 8.5/, улсын сүлжээний станц /8.7, 24.1.14, /, ус цаг уур, орчны станц/14.2.5/, станцын төрөл /20.1.4/, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний станц /21.1.1/, ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний станц /22.1.2/, ажиглалтын станц / 6.1, 8 дугаар зүйлийн гарчиг, 8.1, 8.2/, улсын сүлжээний ажиглалтын станц /8.3/ гэж маш олон янзаар бичиж, төрийн байгууллагын бүтцийн нэгж болох “станц”, “ажиглалтын станц” ойлголтыг ялгааг

тодорхойгүй болгосон байна. Ийнхүү “станц” нэр томъёог олон янзаар тодотгон хэрэглэсэн нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

- Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 6.1-д “ус цаг уур” гэж таслалгүйгээр тодорхойлсон атлаа төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “ус, цаг уур” гэж, төслийн гуравдугаар бүлгийн гарчигт “ус, цаг уур” гэж таслалтайгаар, 4.15-д “усан мандал” гэж устай холбоотой шинжлэх ухааны үг хэллэгийг 3 янзаар хэрэглэсэн нь төөрөгдөлд оруулахаар байна. “Ус цаг уур” гэсэн шинжлэх ухааны үг хэллэгийг иргэд, хуулийн этгээд мэдэж хэрэгжүүлэхээс илүүтэйгээр “цаг агаар” гэдэг ойлголтыг мэдэх нь чухал гэж үзэж байна. Иймд төслийн 4.1.1-д заасан “ус цаг уур” гэсэн нэр томъёог эргэн харах.

3.2.2.4.Ойлгомжгүй нэр томъёо

-Төслийн 4.1.16-д “цаг агаарт зориудаар нөлөөлөх” гэж шинжлэх ухаан, технологийн шийдлээр агаар мандлын процессод зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг ойлгоно хэмээн “цаг агаарт зориудаар нөлөөлөх” гэж... агаар мандлын процессод зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон ойлгомжгүй байна.

-Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.5-т “дээд агаар мандлын” станц нь улсын сүлжээний станцын нэг төрөл байхаар заасан. Эндээс үзэхэд “дээд агаар мандал”, “доод агаар мандал” гэсэн ойлголт гэж ойлгогдохоор байгаа бөгөөд энэ нь агаарын мандлын дээд, доод давхаргаас хэрхэн ялгагдах нь тодорхойгүй байна.

3.2.2.5.Агуулгын давхардал үүсгэж байгаа нэр томъёо

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалт” гэж мал аж ахуй, таримал ургамал, бэлчээрийн ургамлын, хөрсний төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг ажиглах, хэмжих үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон атлаа төслийн 8 дугаар зүйлийн 8.2.7-д “мал аж ахуйн цаг уурын” гэсэн шинэ станц байхаар зааж, агуулгын давхардал үүсгэж байна.

3.2.2.6.Агуулгын зөрчил үүсгэж байгаа нэр томъёо

Төслийн 4.1.19-д “шинжилгээний талбай” гэж ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалтаар сонгон авч төхөөрөмжилсөн, хашаалсан болон өөр бусад байдлаар тэмдэглэж, заагласан орон зайг ойлгоно гэж, 10.1-д “ Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх шинжилгээний талбай нь тусгайлан сонгон авч, төхөөрөмжилсөн, заагласан газар байна” гэж заажээ.

Ийнхүү “шинжилгээний талбай” гэсэн ойлголтыг сонгон авч төхөөрөмжилсөн “орон зай” болон “газар” гэж өөр өөрөөр томъёолсон нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2-т заасан “нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх” гэсэн шаардлагатай нийцэхгүй байна.

Иймд “шинжилгээний талбай” гэсэн ойлголтыг газар гэсэн ойлголттой уялдуулан тодорхойлох

3.2.3.Эрх зүйн хийдэл үүсгэж байгаа зохицуулалт

-Төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ нь ус, цаг уур, орчны төлөв байдлыг ажиглах, хэмжих, мэдээллээр хангах зорилго бүхий ... ажиглалт, хэмжилтийн цэгүүдээс бүрдэнэ гэж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт улсын сүлжээнд хамаарах .. ажиглалт, хэмжилтийн цэг нь төрийн өмч байна” гэж заажээ. Гэвч ажиглалт, хэмжилтийн цэг гэж юуг ойлгох, түүний байршлийг хэн тогтоох, уг цэг түр хугацаанд ажиллах уу, эсхүл байнгын ажиллагаатай байх уу, уг цэгт хүний оролцоо байх эсэх, эсхүл автоматжуулсан багаж, систем, дижитал болон зайнаас тандах технологи, хиймэл оюун ухаанд суурилсан байх уу, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар ус цаг уур, орчны шинжилгээний ажлыг гэрээгээр хийлгэж болох

эсэх, хэмжилт ажиглалтын цагийн хэрхэн байгуулах, ажиглалт, хэмжилтийн мэдээлэл, өгөгдөл нь ямар байх, өгөгдлийг хэзээ хэрхэн дамжуулах, ямар үндэслэлээр үйл ажиллагааг нь зогсоох талаар зохицуулалтгүй үлджээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт нэр томьёо нь олон утгатай бол, эсхүл өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол, шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол нэр томьёоны тайлбар хийхээр хуульчилсан байна.

Тухайн салбарын мэргэжилтнүүдийн мэдвэл зохих мэргэжлийн нэр томьёог хуулиар биш нэр томьёоны тайлбарын стандарт, эсхүл салбарын нэр томьёоны толь гаргах замаар шийдвэрлэх нь зүйтэй.

- Ус цаг уурын ажиглалт, хэмжилтийн цэг (өртөө, харуул) нь агаар мандал, гадаргын ус болон хөрсний төлөв байдалд шинжлэх ухааны үндэслэлтэй байнгын хэмжилт, ажиглалт хийдэг газар юм. Эдгээр цэгүүдээс цуглуулсан өгөгдөл нь цаг агаарын урьдчилсан мэдээ, гамшгийн дохио болон уур амьсгалын судалгааны үндэс суурь болдог. Төслийн 6.5 дахь хэсэгт “Төрөөс ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын үйлчилгээний инновац, судалгаа, дэвшилтэт технологи хөгжүүлэх үйл ажиллагаа болон хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.” Гэж заасан боловч хувийн хэвшлийг хэрхэн дэмжих нь тодорхойгүй байна.

-Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг 10 жилийн хугацаагаар батлах бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчилж болно.” гэж заажээ. Шаардлагатай тохиолдолд гэдэгт юу хамаарах, ямар үндэслэлээр энэхүү төлөвлөгөөг өөрчлөх нь тодорхойгүй байна.

-Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт улсын сүлжээний ажиглалтын станц бүр ажиглалт, хэмжилтийн хөтөлбөртэй байна” гэж заасан боловч ажиглалт, хэмжилтийн цэг нь ажиглалт, хэмжилтийн хөтөлбөртэй байх эсэх нь тодорхойгүй байна.

-Төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд агаар, ус, хөрс, ургамал, хөнөөлт шавьж, хортон мэрэгч, мал амьтдын хувьсал, өөрчлөлтийн үйл явц, ган, зуд, бэлчээр, цөлжилтийн төлөв байдлын судалгаа, дүгнэлт болон байгаль орчны бусад үзүүлэлтүүд хамаарна.

-Төслийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт “хувийн эзэмшлийн газар, барилга байгууламжийг шинжилгээний ажиглалт, хэмжилт хийхэд ашиглаж болно” гэж заасан боловч ямар тохиолдолд ашиглах, үнэ төлбөртэй байх эсэх нь тодорхойгүй байна.

-Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг нийтийн болон тусгай хэрэгцээний мэдээ гэж ангилснаас гадна урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, тэдгээрийн төрлийг тодорхой заасан боловч бодит мэдээ гэдэгт юуг ойлгох талаар тодорхойгүй үлдээсэн байна.

-Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д заасан “5.1.6. мэдээлэл солилцооны уялдаа, нийцлийг хангасан байх” гэсэн зарчим нь хэм хэмжээ агуулж байх тул холбогдох хэсэгт шилжүүлэх.

3.2.4.Товчлол хийсэн байдал

Хуулийн төсөл боловсруулах аргачлалын 4.3.1-д “хуулийн төсөлд олон дахин давтагдаж байгаа нэг ойлголт, нэр томьёог хэд хэдэн үгээр илэрхийлэх тохиолдолд тэдгээрийг товчлон цөөн үгээр илэрхийлэх зорилгоор товчлол хэрэглэнэ” гэж, 4.3.2.товчлол хийхдээ тухайн тодотгож байгаа бусад үгийг хасч, агуулгыг голлон илэрхийлсэн үгийг бичих замаар товчлол хийнэ гэж заасан байдаг.

Гэтэл төслийн 27 дугаар зүйлийн гарчиг нь “**Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ**” боловч 27.1 дэх хэсэгт “энэ хуульд заасан ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилт

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.Хуулийн төслийн гарчиг; 28.1.2.Хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.Зүйлийн доторх хэсэг; 28.1.4.Хэсгийн доторх заалт; 28.1.5.Заалтын доторх дэд заалт; 28.1.6. Шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

(цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх) гэж товчлогыг буруу хийсэн байна.

3.2.5.Хуулийн төслийн бүтэц, хэлбэрт тавигдах шаардлага

Дүгнэлт:Нэр томъёог олон янзаар тайлбарласан, агуулгын давхардалтай, зөрчилтэй байгаа, товчлол буруу хийсэн, зохицуулалтыг бүрэн гүйцэт хийгээгүй зэрэг нь хуулийн эх бичвэрийг ойлгомжгүй болгож, улмаар хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулахаар байна.

3.3.Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал

3.3.1.Хуулийн төслийн 6 ба 8-р зүйлийг үнэлсэн байдал

Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн эсэх, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх эсвэл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгож чиг үүрэг нэмсэн эсэхийг шалгаж, үр нөлөөг үнэлнэ. Энэ хүрээнд хуулийн төслийн 6-р зүйлд заасан станцыг ажиллуулах, 8-р зүйлд заасан станцыг байгуулахтай холбогдсон зохицуулалтыг авч үнэлэв.

Үүрэг болгосон субъект	Хүчин төгөлдөр хууль	Хуулийн төсөл	Хүлээн зөвшөөрөгдөх эсэх
Улсын сүлжээ: Энэ нь төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгож буй зохицуулалт.	9.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ /цаашид "улсын сүлжээ" гэх/ нь нэгдмэл арга зүй, байнгын тасралтгүй ажиллагаатай - өртөө, - харуул, - хүрээлэн, - төв, - лаборатори зэргээс бүрдэнэ.	6 дугаар зүйлд “ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ” байгуулж, - ажиглалтын станц, - лаборатори, - хэмжилтийн цэгүүдээс	Хуулийн төсөлд улсын сүлжээний бүрэлдэхүүн хэсэгт хүрээлэн, төвийг оруулаагүй. Харин өртөө, харуулыг ажиглалтын станц, хэмжилтийн цэгүүд байхаар тусгасан. Сүлжээний бүрэлдэхүүнд зарчмын өөрчлөлт оруулаагүй харагдаж байна.

		бүрдүүлнэ гэж заасан.	
Станцын төрөл: төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлж байгаа эсэх.	3.1.6."Тусгай хэрэгцээний мэдээ" гэж хөдөө аж ахуй, зам тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тодорхой салбарын онцлогийг харгалзсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар гаргаж байгаа ус цаг уур, орчны мэдээг.	8 дугаар зүйлд цаг уурын, ус судлалын, орчны хяналт шинжилгээний, хөдөө аж ахуйн цаг уурын, дээд агаар мандлын, радарын, мал аж ахуйн цаг уурын, нарны цацраг судлалын зэрэг олон төрлийн станц байгуулахыг заасан.	Хэдийгээр улсын сүлжээний бүрэлдэхүүн хадгалагдаж байгаа боловч хуулийн төсөлд станцын 8 төрлийг тодорхойлж оруулсан.
Санхүүжилт: төсөвт нэмэлт ачаалал үүсгэсэн эсэх.	9.4.Улсын сүлжээний өртөө харуулыг байгуулах, төхөөрөмжлөх, татан буулгах, багаж хэрэгслээр хангах зардал болон ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	6.4-т улсын сүлжээний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан	Улсын төсвөөс хүчин төгөлдөр хуулийн хүрээнд улсын сүлжээний өртөө, харуулыг бага хэрэгслээр хангах зардал болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг. Гэхдээ станцуудын төрөл, тоо, нягтрал ихсэхээр төсөв нэмэгдэнэ. Хуулийн төсөлд 10 жилийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй болосруулж, түүнд станц, цэгийн тоог тусгаж байгуулахаар байгаа ба үе шаттайгаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

Хуулийн төсөлд “ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ” байгуулж, ажиглалтын станц, лаборатори, хэмжилтийн цэгээс бүрдүүлэх ба цаг уурын, ус судлалын, орчны хяналт шинжилгээний, хөдөө аж ахуйн цаг уурын, дээд агаар мандлын, радарын, мал аж ахуйн цаг уурын, нарны цацраг судлалын зэрэг төрөлжсөн станц байгуулах асуудлыг тусгасан. Мөн улсын сүлжээний үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, иргэдэд аюулт үзэгдэл, гамшгийн мэдээллийг хүргэх үүргийг төр хүлээх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Монгол Улс нь уур амьсгалын эрс тэс нөхцөлтэй, ган, зуд, үер, хүчтэй салхи, шороон шуурга, ой хээрийн түймэр зэрэг гамшгийн давтамж өндөртэй, эдийн засгийн бүтэц нь хөдөө аж ахуй, бэлчээрийн мал аж ахуйгаас өндөр хамааралтай, усны нөөц хомс, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг орны нэг юм.

Дэлхийн дулаарлын улмаас Монгол орны уур амьсгал илт өөрчлөгдөж, сүүлийн 80 жилийн хугацаанд гадаргын температур 2.4 градусаар нэмэгдсэн.¹²

Цаг уур, орчны шинжилгээний газар нь улсын хэмжээнд цаг уурын ажиглалтын 137 станц, 181 хяналтын цэг, 152 ус цаг уурын станцын сүлжээг ажиллуулж, урьдчилан таамагласан хугацаанаас хамааран маш богино хугацааны (3/6/12 цаг), богино хугацааны (3 өдөр), дунд хугацааны (7 хоног), нэг сар, улирлын (гурван сар) цаг агаарын урьдчилсан мэдээ гаргадаг. Мөн агаарын чанар, гадаргын усны чанар, хөрсний чанар зэрэг хөдөө аж ахуй, байгаль орчинтой холбоотой усны түвшин, салхины хурд зэрэг урьдчилсан мэдээгээр хангадаг.

Гэсэн хэдий ч олон төрлийн аюулт үзэгдлийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан цаг агаарын мэдээг бусад салбаруудын мэдээлэлтэй нэгтгэж, салбар бүрийн цаг агаарын үзэгдлийн нөлөөллийг авч үздэг нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглал чухал байгааг дээрх тайланд дурджээ.

Цаг уур судлалын өндөр хөгжилтэй орнууд хүртэл цаг уурын үзэгдэл бүрийн нөлөөнд суурилсан урьдчилсан мэдээг эрчимтэй хөгжүүлэхээр ажиллаж өргөжүүлж байна.

Улсын хэмжээнд нэгдсэн сүлжээ байгуулж, төрөлжсөн станцын эрх зүйн үндсийг тодорхой болгохоор хуулийн төсөлд тусгасан нь үзэл баримтлалд дурдсан уур амьсгалын өөрчлөлтийн явц, түүний сөрөг үр дагавар, нөлөөллийг таасралтгүй ажиглаж хянах, болзошгүй аюул, эрсдэлийг судлан тогтоох, байгалийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт, дүгнэлт гаргах, холбогдох бодлого, хууль эрх зүйн орчныг оновчтой бүрдүүлэх шаардлага тулгарч байна гэсэн зорилготой нийцэж байна. Станцын төрлүүдийг нарийвчлан тогтоосноор дараах эерэг үр нөлөө гарна.

Хуулийн төсөлд тусгасан:

- улсын сүлжээний ажиглалтын станцыг ерөнхий төлөвлөгөөний дагуу байгуулах (8.3);
- улсын сүлжээний ажиглалтын станц бүр ажиглалт, хэмжилтийн хөтөлбөртэй байх (8.1);
- ажиглалтын станц, лаборатори, хэмжилтийн цэгийн тогтолцоог бүрдүүлэх (6.1);
- станцууд нь цаг уурын, ус судлалын, орчны хяналт шинжилгээний, хөдөө аж ахуйн цаг уурын, дээд агаар мандлын, радарын, мал аж ахуйн цаг уурын, нарны цацраг судлалаар төрөлжсөн байх (8.2);
- Ус цаг агаар, орчны аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эхний ээлжид шуурхай дамжуулах (13.3).

зэрэг зохицуулалт нь гамшгийн эрсдэлийг бууруулах, эдийн засгийн шууд болон шууд бус хохирлыг багасгах стратегийн ач холбогдолтой.

¹² Гамшиг, уур амьсгалын эрсдлийг удирдах чадавхын үнэлгээ, 2024 он, НҮБ, ГЭБЧБТүншлэл, Дэлхийн зөн

3.3.1.1. Нийгмийн үр нөлөө: Иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах

Манай улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 63 удаа тохиолддог байсан бол сүүлийн 10-аад жилд жилд дунджаар 99 болж нэмэгдсэн ба 2001-2025 оны хооронд 599 хүн амь эрсдсэн байна.¹³

Хуулийн төслийн дээр дурдсан заалтууд үер, хүчтэй салхи, шуурга, зуд, хэт халалт, хүйтррэл, аянга, мөндөр, ой, хээрийн түймрийн эрсдлийг урьдчилсан мэдээлэх эрх зүйн орчин цогцоор бүрдэж, иргэдийг аюулт үзэгдэл, гамшгийн талаарх эрт сэрэмжлүүлгийн тогтолцоог сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, орон нутгийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Тухайлбал, хөдөө аж ахуйн цаг уурын болон мал аж ахуйн цаг уурын станц байгуулснаар бэлчээрийн даац, төлөв байдал, хөрсний чийг, ган, зудын эрсдэл, тариалалт, хураалтад тохиромжтой хугацаа зэрэг мэдээллийг эрт мэдсэнээр малчид, тариаланчдын аж ахуйгаа цаг агаар, орчны байдалтай уялдуулан шийдвэр гаргахад үр нөлөө үзүүлнэ. Ингэснээр малын хорогдол буурах, ургацын алдагдал багасах, хөдөө аж ахуйн бүтээмж нэмэгдэх, даатгалын үнэлгээ бодит болох, эрсдэлийн удирдлага сайжрах эерэг нөлөөтэй.

3.3.1.2. Эдийн засгийн үр нөлөө: Гамшгийн хохирлыг бууруулна

Сайжруулсан сүлжээ нь гамшгийн урьдчилан сэргийлэлтийг сайжруулах, хөдөө аж ахуйд учрах хохирлыг бууруулах, дэд бүтцийн эвдрэлээс сэргийлэх, тээвэр, нисэх, эрчим хүчний салбарын эрсдэлийг бууруулах замаар эдийн засгийн шууд болон шууд бус хохирлыг бууруулна.

Гарз хохирлын хувьд, 2009-2010 оны өвөл тохиолдсон зудад нутаг дэвсгэрийн 80.9 хувь буюу 18 аймгийн 175 суманд 97.5 малчин өрх нэрвэгдэж, 10.3 сая толгой мал хорогдсон. Энэ нь зах зээлийн дундаж үнээр 570.0 тэрбум төгрөгийн хохирол амссан гэсэн үг юм. Зудын гамшгийн улмаас 8711 өрх айл малгүй болж амьжиргааныхаа эх үүсвэрээс салж, 32756 мянган малчин өрх малынхаа 50-иас дээш хувийг алдаж, 1400 малчин төв суурин газар бараадаж нүүсэн байна.

Монгол Улс нь зуд, ган, үер, шороон шуурга, ой хээрийн түймэр зэрэг ус цаг уурын гаралтай гамшигт өндөр өртөмтгий орны нэг бөгөөд энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний хангамжид болон бусад байдлаар тодорхой хэмжээний хохирол учруулж ирсэн.

Монгол оронд 1940 оноос хойш олон удаагийн зуд тохиолдож, ихээхэн хэмжээний мал хорогдож байжээ¹⁴, тухайлбал, 2009–2010 оны зуд нь Монгол Улсын түүхэн дэх хамгийн хүнд зудын нэг бөгөөд улсын нутаг дэвсгэрийн 80.9 хувь нь зудын нөхцөлд өртөж, 10.3 сая толгой мал хорогдсон нь тухайн үеийн нийт мал сүргийн 23.4 хувь-тай тэнцэж байжээ. Түүнийг зах зээлийн дундаж үнээр 570 тэрбум төгрөгийн хохирол байна.

Монгол оронд түгээмэл тохиолддог зуд зөвхөн малын хорогдол бус хөдөөгийн ядуурал, дотоод шилжилт хөдөлгөөн, хотод төвлөрөх, хүнсний хангамж, экспортын

¹³ <https://namem.gov.mn/d/news/160>

¹⁴ Монгол оронд 1940 оноос хойшхи зудын давтамжийг харвал 1944-1945 оны зуданд 8.2 сая, 1954-1955 онд 1.9 сая, 1956-1957 онд 1.5 сая, 1967-1968 онд 2.7 сая, 1976-1977 онд 2.0 сая, 1986-1987 онд 0.8, 1993 онд 1.6 сая, 1999-2000 онд 3.5, 2000-2001 онд 4.8 сая малаа ган зуданд алдаж байжээ. Мөн 2001-2002 онд 2.9, 2009-2010 онд 10.3 сая мал хорогдсон нь нийт малын 23.4 хувийг эзэлж байв. Өөрөөр хэлбэл, 2000-2001 оны зуданд 4.8 сая малаа алдсан бол 2009-2010 оны бар жилд нийт малынхаа 23.4 хувийг байгалийн гамшигт алдсан байна.

орлогод болон үндэсний эдийн засагт томоохон сөрөг нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр 2024 онд улсын хэмжээнд цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл нийт 104 удаа бүртгэгдсэн, үүнээс байгалийн аюултай үзэгдэл — 95 удаа, гамшигт үзэгдэл — 13 удаа болсон байна. Үүний улмаас 3 хүн амь насаа алдсан, 3,058,998 толгой мал хорогдсон, улсын чанартай авто зам, гүүр эвдэрсэн, эрчим хүчний шон унасан, гэр нурсан, барилгын дээвэр хуурсан, хашаа эвдэрсэн, шороон шуурганд автомашины шил хагарсан, тариалангийн талбай өртсний улмаас нийт 3,3 тэрбум орчим төгрөгийн шууд хохирол учирсан байна. Мөн 2024 онд ой, хээрийн түймэр 137 удаа бүртгэгдэж, 1,7 орчим тэрбум төгрөгийн шууд хохирол учруулсан байна.

Олон улсын сайн туршлагаас харвал, Япон Улс нь аадар бороо, үерийн эрт сэрэмжлүүлгийн систем нэвтрүүлснээр иргэдийг нүүлгэн шилжүүлэх хугацаа мэдэгдэхүйц сайжирч, үерийн үеийн нас баралт болон дэд бүтцийн хохирлыг бууруулсан гэж үнэлдэг. Тухайлбал, 2019 оны Hagibis хар салхины үед олон сая иргэнд урьдчилсан сэрэмжлүүлэг хүргэж, өндөр эрсдэлтэй бүсээс урьдчилан нүүлгэн шилжүүлэлт хийснээр болзошгүй хохирлыг мэдэгдэхүйц бууруулсан.

Япон Улс нь 1,300 гаруй автомат ажиглалтын станц, үндэсний доплер радарын сүлжээ, өндөр нарийвчлалтай эрт сэрэмжлүүлгийн систем ашигладаг бөгөөд 2019 оны Hagibis хар салхины үеэр 6 сая гаруй иргэнд нүүлгэн шилжүүлэх сэрэмжлүүлэг хүргэж, өндөр эрсдэлтэй бүсээс урьдчилан нүүлгэн шилжүүлэлт зохион байгуулсан байна. Японы ус цаг уурын агентлагийн мэдээлэл болон олон улсын эх сурвалжуудад дурдсанаар энэхүү эрт сэрэмжлүүлгийн тогтолцоо нь үер, хөрсний гулсалт, хар салхины үеийн хүний амь нас, дэд бүтцийн болзошгүй хохирлыг бууруулахад чухал нөлөө үзүүлсэн гэж үнэлэгддэг.¹⁵

БНСУ-д үер, халалтын давалгаа, хар салхи, аадар борооны эрт сэрэмжлүүлгийн тогтолцоог хөгжүүлснээр цаг агаарын гамшгийн үеийн эдийн засгийн алдагдлыг бууруулах, нисэх, авто тээвэр, эрчим хүчний салбарын эрсдэлийг багасгах, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх үр нөлөө гарсан гэж үнэлдэг.

Дэлхийн цаг уурын байгууллагын судалгаагаар орчин үеийн эрт сэрэмжлүүлгийн системд оруулсан 1 ам.долларын хөрөнгө оруулалт 4–10 ам.долларын эдийн засгийн өгөөж өгдөг болохыг тогтоосон. ДЦУБ болон Бүгдэд нь эрт сэрэмжлүүлэг санаачилгаас 24 цагийн өмнөх сэрэмжлүүлэг нь гамшгийн хохирлыг 30 хүртэл хувиар бууруулах боломжтой гэж үнэлсэн байна.¹⁶

Иймээс хуулийн төсөлд тусгасан улсын нэгдсэн сүлжээ, төрөлжсөн станцуудын тогтолцоо нь Монгол Улсад зуд, үер, ган, шороон шуурга, ой хээрийн түймэр, агаарын аюултай үзэгдлийн эрсдэлийг бууруулж, урт хугацаанд улсын эдийн засгийн тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой гэж үзэж байна.

3.3.1.3. Байгаль орчны үр нөлөө: Үндэсний бодлогын зорилт болон олон улсын үүрэг амлалт сайжирна.

Хуулийн төслийн 6 ба 8-р зүйлд заасан орчны хяналт шинжилгээний болон нарны цацраг судлалын станц байгуулснаар агаарын чанарын мониторинг, хүлэмжийн хийн ажиглалт, цөлжилтийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлт, озон, нарны цацрагийн

¹⁵ Typhoon Hagibis: millions across Japan told to evacuate homes, Japan, The Guardian, <https://www.theguardian.com>, 2019

¹⁶ Early Warnings For All Initiative scaled up into action on the ground, press releases, 21 March 2023, WMO

хэмжилт сайжирна. Энэ нь: олон улсын жишиг, сайн туршлагад тулгуурлан үндэсний хэмжээнд уур амьсгалын бодлого боловсруулах, улмаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт хэрэгжихэд болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтад хүрэхэд хувь нэмэр оруулахад чухал ач холбогдолтой.

3.3.2.Хуулийн төслийн 14-р зүйлд заасан Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн системийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ

Хуулийн төсөлд Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн системийг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбар нь мэдээ, мэдээллийн нэгдсэн сантай байх (14.1), тус сангийн үйл ажиллагаа, бүрдүүлэлт, ашиглах асуудлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцахаар (14.3) тусгасан.

Хүчин төгөлдөр хууль	Хуулийн төсөл
13 дугаар зүйл.Ус цаг уур, орчны мэдээлэл дамжуулах 13.1.Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг харилцаа холбооны байгууллага хяналтын хугацаанд саадгүй дамжуулна. 13.2.Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг нэгтгэж олон улсын цаг уурын харилцаа холбооны сүлжээнд оруулах, уг сүлжээнээс Монгол Улсад шаардагдах мэдээллийг хүлээн авахад дотоодын болон олон улсын холбооны суваг ашиглана. Уг сувгаар газар хөдлөл, химийн болон цөмийн осол, иргэний агаарын тээврийн нислэгт зориулсан цаг уурын мэдээ зэрэг бусад шуурхай мэдээг дамжуулж болно. 13.3. Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай ус цаг уур, орчны шинжилгээний аль ч байгууллагад яаралтай мэдээлэх үүрэгтэй. Ийнхүү мэдээлэхтэй холбогдсон зардлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон үнэлгээний	14 дүгээр зүйл. Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан 14.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбар нь мэдээ, мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд уг сан нь төрийн өмч байна. 14.2. Нэгдсэн сан нь дараах ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллээс бүрдэнэ. 14.2.1. Ус, цаг агаар, уур амьсгал, орчны ажиглалт, хэмжилтийн мэдээ, баримт; 14.2.2 гадаад улс, олон улсын байгууллагаас хүлээн авсан мэдээ, баримт; 14.2.3 хиймэл дагуулын мэдээнд суурилсан ой, хээрийн түймэр, ургамалжилт, цасан бүрхүүл, хөрсний сэдэвчилсэн зураглал 14.2.4 ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, төлөв байдлын тойм; 14.2.5. ус цаг уур, орчны станц, хэмжих хэрэгслийн техникийн бүртгэл 14.2.6. ус цаг уур, орчны шинжлэх ухааны судалгаа, төсөл хөтөлбөрийн үр дүн; 14.2.7. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа, үр дүн; 14.2.8. техникийн заавар, үйл ажиллагааны журам. 14.2.9. Байгаль орчны төлөв байдлын тайлан 14.2.10. Озон, хүлэмжийн хий, мал аж ахуй, газар бүрхэвчийн салбарын хүлэмжийн хийнүүдийн ялгаралт, озон задалдаг бодисуудын тоо бүртгэл

дагуу иргэнд нөхөн олгож болно. 13.4. Аюулт үзэгдэл, гамшгийн тухай мэдээллийг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн ялгаа харгалзахгүйгээр эхний ээлжинд шуурхай дамжуулна.	14.2.11. Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлттэй холбогдох хүлэмжийн хийн шингээлт 14.3. Нэгдсэн сангийн үйл ажиллагаа, бүрдүүлэлт, ашиглах асуудлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна. 14.4. Нэгдсэн сангийн өгөгдөл, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах, кибер аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.
--	---

Хуулийн төсөлд 4-р бүлгийн 14 дүгээр зүйлд Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн систем байгуулахтай холбоотой зохицуулалтыг шинээр тусгаж, ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийн мэдээ, гадаад улс болон олон улсын байгууллагаас хүлээн авсан мэдээлэл, хиймэл дагуулын зураглал, урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, хүлэмжийн хийн бүртгэл, судалгаа шинжилгээний үр дүн, техникийн бүртгэл зэрэг мэдээллийг төвлөрүүлсэн нэгдсэн системтэй байхаар тусгажээ. Мөн уг системийн өгөгдлийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, кибер хамгаалалт, цахим архив, мэдээллийн баталгаажуулалттай холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

Энэхүү зохицуулалт нь ус цаг уур, орчны салбарын мэдээллийн удирдлагыг орчин үеийн дата төв, нэгдсэн платформд суурилсан тогтолцоонд шилжүүлэх суурь эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа ач холбогдолтой. Улсын нэгдсэн сүлжээтэй болсноор мэдээллийн урсгал нэг стандарттай болж ус цаг уур, орчны урьдчилан сэргийлэх болон бодит мэдээлэл нэг платформд цогцоор төвлөрнө. Үүний үр дүнд өгөгдлийн чанар сайжирна, байгууллагуудын давхардал багасна, мэдээлэл солилцоо түргэн, шуурхай болно, олон улсын стандарттай нийцэл нэмэгдэж, төрийн үйлчилгээний үр нөлөө сайжирна.

3.3.2.1. Нийгмийн үр нөлөө: Иргэдийн аюулгүй байдлыг хангах, эрт сэрэмжлүүлгийн тогтолцоог сайжруулах үр нөлөө

Нэгдсэн мэдээллийн систем бий болсноор ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээллийг бодит хугацаанд нэгтгэн боловсруулах, байгууллагууд хооронд шуурхай солилцох, иргэдэд богино хугацаанд хүргэх боломж бүрдэнэ.

Одоогийн хүчин төгөлдөр хуулийн 13-р зүйлээр зохицуулагдаж байгаа ус цаг уур, орчны мэдээлэл дамжуулах хүрээнд ус цаг уур, орчны мэдээлэл нь салангид сан, архив, байгууллагуудад хадгалагдаж байгаа нь мэдээллийн уялдаа, ашиглалтыг сулруулж, аюулт үзэгдлийн үед шийдвэр гаргах хугацааг удаашруулах эрсдэлтэй байна.

Нэгдсэн систем бий болсноор дараах эерэг үр нөлөөтэй:

- аюулт үзэгдэл, гамшгийн талаарх сэрэмжлүүлгийг богино хугацаанд боловсруулах;
- орон нутгийн эрсдэлийг бодит хугацаанд тодорхойлох;
- төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- иргэдийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх;

- хүний амь нас, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах.

ДЦУБ-ын үнэлгээгээр 24 цагийн өмнө хүргэсэн эрт сэрэмжлүүлэг нь гамшгийн хохирлыг 30 хүртэл хувиар бууруулах боломжтой гэж үздэг. Монгол Улсад 2024 онд цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл 104 удаа бүртгэгдэж, 3 хүн амь насаа алдаж, 3,058,998 толгой мал хорогдсон нь мэдээллийн шуурхай, нэгдсэн тогтолцоо шаардлагатайг харуулж байна.

3.3.2.2. Малчид, тариаланчдын мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх үр нөлөө

Хуулийн төсөлд хиймэл дагуулын мэдээнд суурилсан цасан бүрхүүл, ган, зуд, бэлчээрийн ургац, даац, ой, хээрийн түймрийн зураглалыг нэгдсэн системд оруулахаар тусгасан нь мал аж ахуй, газар тариалангийн салбарт чухал ач холбогдолтой. Малчид, тариаланчид цаг агаарын урьдчилсан болон бодит мэдээг радиогоор чих тавин сонсдог уламжлал нь одоо ч хадгалагдаж байгаа. Мөн гар утас, телевизээс цаг уурын мэдээг тогтмол үзэж, харж мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлээ зохицуулж эрхэлсээр байна. Тиймээс цаг агаарын мэдээллийг нэгдсэн платформд оруулснаар малчид, тариаланчид төдийгүй төр засгийн холбогдох байгууллага цаг агаарын урьдчилсан болон бодит мэдээлэл, улмаар олон жилийн цаг агаарын төлөв байдлын талаар мэдээллийг нэг сувгаар авах боломж бүрдэх ба зудын эрсдэлийг эрт тодорхойлох, бэлчээрийн төлөв байдалдаа тохируулах, отор нүүдлийг төлөвлөх, тариалалт, хураалтын хугацааг оновчтой тогтоох, үер, ус, салхи, шуурга, аадар борооны эрсдэлийг үнэлэх, хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоо хөгжих, идэвхжих боломжийг нэмэгдүүлнэ.

Монгол Улсад 2009–2010 оны зудын үед 10.3 сая толгой мал хорогдож, 97.5 мянган малчин өрх нэрвэгдэн, 570 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь эрсдэлийн мэдээллийг эрт боловсруулах, нэгтгэн хүргэх тогтолцоо чухал болохыг харуулж байна.

ДУЦБ болон ДБ-ны үнэлгээгээр эрт сэрэмжлүүлгийн системд оруулсан 1 ам.долларын хөрөнгө оруулалт нь 4–10 ам.долларын эдийн засгийн өгөөж бий болгодог байна.

Иймд ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн систем байгуулах зохицуулалт нь:

- гамшгийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах;
- эрт сэрэмжлүүлгийн тогтолцоог бэхжүүлэх;
- мэдээллийн шуурхай байдлыг нэмэгдүүлэх;
- төрийн цахим шилжилтийг дэмжих;
- эдийн засгийн хохирлыг бууруулах;
- байгаль орчны мониторингийг боловсронгуй болгох

урт хугацааны стратегийн өндөр ач холбогдолтой зохицуулалт гэж үзэж байна. Иймээс хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үнэлэв.

3.4. Практик хэрэгжих шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг байдал

Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авлаа. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулга бүхий зохицуулалтын үр нөлөөг тооцсон болно.

3.4.1.Хуулийн төсөл дэх ус цаг уур, орчны мэдээллээр хангах үйлчилгээ

Практикт хэрэгжих боломж: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, хэсэг, заалт
1	Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээний зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх	27 дугаар зүйл.Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ 27.1.Энэ хуульд заасан ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилт (цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх)-ийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болно.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн агуулгаас үзэхэд 1-рт, энэ хуульд заасан ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилт /цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх/-ийн үйлчилгээг тусгай зөвшөөрлөөр эрхлэх, 2-рт, энэхүү үйлчилгээг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд эрхлэхээр заажээ. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд гэдэг нь Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу өөрийн тусгаарласан хөрөнгөтэй, өмнөөсөө үүрэг хүлээж, бусад этгээдтэй харилцахдаа эрх эдлэн хариуцлага хүлээх чадвартай, Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан ёсоор бүртгүүлсэн байгууллагыг ойлгоно.

Энэ нь нэг талаас төрийн төрийн хийх ёстой нийтийн зориулалтай үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, үйлчилгээний боломжит байдлын эрсдлийг хувийн талд шилжүүлж, төсвийн санхүүгийн эх үүсвэрийг бууруулах ач холбогдолтой дэвшилтэт зохицуулалт болжээ. Гэвч нөгөө талаас Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн “Тусгай зөвшөөрөл” гэсэн хэсэгт “ус цаг уурын үйлчилгээ” гэсэн заалт байхгүй.

Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.” гэж, 5 дахь хэсэгт Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргахаар, 9.3 дугаар зүйлд зөвшөөрөл шинээр бий болгоход дүгнэлт гаргахаар тус тус заасан байна.

Хэдийгээр төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгтэй холбогдуулан холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн “Тусгай зөвшөөрөл” гэсэн хэсэгт “1.32.ус цаг уурын үйлчилгээ” гэж, мөн хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэсэн хэсэгт “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус нэмэхээр Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан боловч Ерөнхий сайдын дэргэд ажиллах Зөвлөлөөс холбогдох санал дүгнэлтийг аваагүй байна.

Ийнхүү Зөвшөөрлийн тухай хуульд заасан процессын журмыг хэрэгжүүлээгүй тохиолдолд энэ нь төслийн 27 дугаар зүйлд заасан Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээтэй холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжгүй болно. Нөгөө талаас нэг талаас Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -ийг УИХ-д өргөн мэдүүлэх бүрдүүлбэрийг хангаагүй гэж үзэх үндэслэл болно.

Иймд төслийн 27 дугаар зүйлийн зохицуулалтын хүчин төгөлдөр мөрдөх хугацааг хойшлуулах, үүнтэй холбоотой Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хууль батлагдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулах замаар Зөвшөөрлийн зөвлөлөөс дүгнэлт гаргуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

3.4.2. Мөнгөн тэтгэмж олгохтой холбогдсон зохицуулалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, хэсэг, заалт
1	Мөнгөн тэтгэмж олгох заалт парктикт хэрэгжих боломжтой юу?	25.3.2. Салбартаа тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох, түүнийг олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална.

Төслийн 25 дугаар зүйлийн 25.3.2-т “Салбартаа тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох, түүнийг олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална” гэж заажээ. Энэ нь нэг талаас орон нутагт ажиллаж байгаа салбарын мэргэшсэн хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, улмаар ус цаг уур орчны шинжилгээ тасралтгүй, тогтвортой хийгдэж, иргэд, хуулийн этгээдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үнэн зөв мэдээ, мэдээллээр шуурхай, хүртээмжтэй хангахад чухал ач холбогдолтой. Гэвч нөгөө талдаа төсвийн ачаалал үүсгэнэ.

Үүнтэй холбоотойгоор бусад салбарын ажилтан албан хаагчдад мөнгөн тэтгэмж олгодог эсэхийг судалж үзэхэд Засгийн газрын тогтоолоор батлагдсан дараах журмууд үйлчилж байна. Үүнд:

-Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 24.1.2-т заасны дагуу баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”¹⁷;

-Соёлын тухай хуулийн 20.1.1, 33.9 дэх хэсэгт заасны дагуу баталсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”¹⁸;

-Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам¹⁹-аар салбартаа тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгохтой холбоотой харилцааг зохицуулдаг;

-Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай

¹⁷Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолын хавсралт

¹⁸Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолын хавсралт

¹⁹ Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 185 дугаар тогтоолын хавсралт

нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална” гэж зааснаар “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”²⁰;

-Шүүх шинжилгээний тухай хуулийн 71.2, 71.3-т заасны дагуу баталсан "Аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид мөнгөн тэтгэмж олгох журам"²¹.

Эндээс үзэхэд 2023-2024 онуудад зарим салбарын төрийн үйлчилгээний албан албан хаагчид болон орон нутгийн төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал, мөнгөн тэтгэмж олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6-д зааснаар ус цаг уур, орчны шинжилгээний албан хаагчдад мөнгөн тэтгэмжийг олгох журмын төсөл нь хууль тогтоомжид нийцсэн, гүйцэд боловсрогдсон, зохих тооцоо, холбогдох яамны виз /санал/-ээр нотлогдсон тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж шийдвэрлэгдэнэ.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-т зааснаар Засгийн газрын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх, 6.2.5-т төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байхаар заасан байна.

Иймд төсөвт нөлөөлөл үзүүлэхээр байгаа төслийн 25 дугаар зүйлийн 25.3.2 дахь заалтын хүчин төгөлдөр болох хугацааг 2027 оноос хэрэгжүүлэхээр төсөлд тусгах шаардлагатай.

3.4.3.Цалин хөлсийг нэмэгдүүлж олгохтой холбогдсон зохицуулалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, хэсэг, заалт
1	Аюултай үзэгдэлтэй үед ажилласан ажилтанд цалин хөлсийг нэмэгдүүлэх олгох боломжтой юу?	25.3.3. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох;

Дүгнэвэл, Гамшгийн тухай хуулиар аюул, аюулт үзэгдэл, ослын улмаас хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон голомтын бүсэд онцгой байдлын албан хаагч, дайчлагдан ажилласан хүнд зөвхөн томилолтын зардлыг гурав дахин нэмэгдүүлж олгохоор заасан байна.

Иймд Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох заалт практик хэрэгжих боломжгүй байна.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн гэж заажээ.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.2-т "аюулт үзэгдэл" гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг, 4.1.11-д "голомтын бүс" гэж гамшиг, аюул, аюулт үзэгдэл, ослын

²⁰ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралт
²¹ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 99 дүгээр тогтоолын хавсралт

улмаас хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон, эсхүл шууд эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг ойлгоно гэж хуульчилснаас гадна 37.1.5-д голомтын бүсэд дайчлагдан үндсэн ажлаас чөлөөлөгдөн үүрэг гүйцэтгэсэн бол цалин хөлсөө ажил олгогчоос, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нэгэн адил томилолтын зардлыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр авах, 50.2 дахь хэсэгт “Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно” гэж заасан байна.

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад аюултай үзэгдлийн үед ажилласан хүнд цалин хөлсийг нэмэгдүүлэн олгох зохицуулалт байхгүй байна.

Иймд төслийн 25.3.3 дахь заалтын “Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох” зохицуулалт практикт хэрэгжих боломжгүй байна.

Харин “аюултай үзэгдэл”-ийн үед голомтын бүсэд ажилласан төрийн албан хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгох зохицуулалтыг холбогдох хууль оруулах асуудлыг судалж үзэх шаардлагатай.

3.4.4.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй холбогдсон зохицуулалт

Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	Хуулийн төсөл
85.2.Эрх бүхий байгууллагаас тухайн ажлын байрыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамааруулахаар тогтоосон бол ажил олгогч ажилтны ажлын цагийг богиносгох үүрэгтэй.	25.3.5. хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанд мөнгөн урамшуулал олгох;
	25.3.6. амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх тохиолдолд мөнгөн урамшуулал олгох;
	25.4.Энэ хуулийн 25.3.5, 25.3.6-д заасан мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Хөдөлмөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 31 дүгээр зүйлд “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллага батлагдсан журмын дагуу хийнэ”, “Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болгох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт нь, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг тус тус хийлгэнэ”, “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж хуульчилжээ.

“Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”²², “MNS 5080:2023/ Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага”, “MNS 4990:2023/Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжилд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартыг үндэслэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийж, тухайн байгууллагын хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийг тогтоодог.

Хөдөлмөрийн тухай хуулийн 85.2-т “Эрх бүхий байгууллагаас тухайн ажлын байрыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамааруулахаар тогтоосон бол ажил олгогч ажилтны ажлын цагийг богиносгох үүрэгтэй” гэж, 115.1-д ажлын цагийг нь богиносгосон ажилтны цалин хөлсийг цагаар, эсхүл хийснээр нь тооцож олгох бөгөөд богиносгосон цагт ногдох цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч нэмж олгоно” гэж, 99.6-д Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь нэмэгдэл амралтыг олгоно гэж, 108.1-д “Ажилтны ... хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно” гэж, гэж тус тус зохицуулжээ.

Иймд ус цаг уур, орчны шинжилгээний алба нь ажлын байрны хөдөлмөрийн үнэлгээ хийлгэсний дараа Хөдөлмөрийн тухай хуульд заасны хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан албан хаагчдын нэмэгдлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Төслийн 25.3.5 /хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байр/, 25.3.6 дахь заалт / амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх/ -д олгон нэмэгдэл нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн зохицуулах харилцаанд хамаарахгүй байх тул практикт хэрэгжих боломжгүй гэж үзэж байна.

3.5.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт бүрийн уялдаа холбоог шалгасан. Мөн хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг сонгон авч, бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн эсэх, агуулгын давхардал үүсгэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, сайжруулах саналыг боловсрууллаа.

3.5.1.Хуулийн төслийн доторх зүйл заалтын уялдаа холбоо

Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах зохицуулалт харилцан уялдаатай байгаа эсэхийг холбогдох зохицуулалтын хүрээнд авч үзье.

3.5.1.1.Ус цаг уур, орчны мэдээ, мэдээлэлтэй холбоотой үг хэллэгийн уялдаа холбоо

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн зорилт нь ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахад чиглэсэн бол төслийн зорилт нь мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийг хангахад чиглэж байна. Монгол хэлний тайлбар тольд “мэдээ” гэдгийг ямар нэг зүйлийн талаар сонсгох, дамжуулах²³ гэсэн утгаар, “мэдээлэл” гэдэг нь ямар нэг үйл баримтын талаар амаар болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх үйл явц, мэдээ дамжуулах, түгээх²⁴ гэсэн утгаар, “мэдээ мэдээлэл” гэсэн хоршоо үг нь

²² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/155 дугаар тушаалын хавсралт

²³ Монгол хэлний тайлбар толь.УБ хот.2014 он, 731 дэх тал

²⁴ Монгол хэлний тайлбар толь.УБ хот.2014 он, 732 дахь тал

олон түмэнд хүргэх, сонсгох үйл хэргийн товч, тойм гэсэн утгаар, “мэдээлэх” гэдэг нь мэдээлэл цацах, тодорхой болгон нийтлэх гэсэн утгаар тус тус тайлбарлажээ.

Гэвч хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн зорилт “мэдээллээр хангах”-д чиглэж байсан бол хуулийн төсөлд хуулийн зорилтыг “мэдээ, мэдээллээр хангах” зорилт болгон өөрчилсөн хэдий ч мэдээ, мэдээллийн ялгаа нь төсөлд төдийлөн харагдахгүй байна. Тухайлбал, төслийн 28.2.1-д “ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээлэл” гэж, 4.1.22-т аюул, өртөмхий байдал, эмзэг байдлын мэдээлэл, 5.1.6-д мэдээлэл солилцооны уялдаа, 19.1.1.ус цаг уур, орчны мэдээлэл, 8.5.4-т ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээлэл, 15.3-т лавлагаа, мэдээлэл, 19.1.1.ус цаг уур, орчны мэдээлэл гэж өмнөө тодотголтой мэдээлэл гэсэн үг хэллэг нь төсөлд хэрэглэсэн “мэдээ” гэдэг үг хэллэгээс ямар ялгаатай нь ойлгогдохгүй байна. Иймд, мэдээ, мэдээллийн хүрээ хязгаар, ялгаа, зориулалтыг тодорхой ялгамжтайгаар төсөлд тусгах.

3.5.1.2.Мэдээ, мэдээллээр хангах зохицуулалт

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.2-т “ус цаг уур, орчны **мэдээллээр** иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай үйлчлэх”, 7.1.3-т “ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай хангах”, 9.1 дэх хэсэгт “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус цаг уур, орчны мэдээллээр хангах”, 12.4 дэх хэсэгт “ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах”, 15 дугаар зүйлийн гарчигт “Ус цаг уур, орчны мэдээллээр хэрэглэгчийг хангах” төрийн байгууллагын чиг үүргийг тодорхой зохицуулсан байна, Харин төслийн 26 дугаар зүйлд Ус цаг уур, орчны үйлчилгээ, 27 дугаар зүйлд Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ гэсэн үг хэллэг хэрэглэж, төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дахь заалт, 26.2-т нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах, 26.1.2-т тусгай хэрэгцээний мэдээгээр хангах, 24.1.6-д хэрэглэгчийг ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллээр шуурхай хангахаар заажээ.

Төслийн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ гэсэн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт ус, цаг уур, орчны төлөв байдлыг ажиглах, хэмжих, мэдээллээр хангах зорилго бүхий ажиглалтын станц, лаборатори, ажиглалт, хэмжилтийн цэгүүдийн талаар, “Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах” гэсэн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах үйл ажиллагаанд хэрэглэгчийг мэдээллээр хангах хамаарна гэж төрийн захиргааны байгууллагын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх чиг үүрэгтэй холбоотойгоор ерөнхий зохицуулжээ.

Төслийн 26, 27 дугаар зүйлийн гарчигт “Ус цаг уур, орчны үйлчилгээ”, 26.1.4, 26.1.8 дахь заалт, 26.6 дахь хэсэгт “цаг уурын үйлчилгээ”, 26.1.6-д “орчны чанарын хяналт шинжилгээ үйлчилгээ”, 22.1.3-т “ус цаг уур, орчны мэдээлэл”, 26.2-д “нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах үйлчилгээ” гэх мэтчилэн өөр үг хэллэгээр хэрэглэж, мэдээллээр хангах үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг ойлгомжгүй болгосон.

Харилцан уялдаа	төслийн холбогдох хэсэг
Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах зохицуулалт харилцан уялдаатай байна уу	26 дугаар зүйл.Ус цаг уур, орчны үйлчилгээ 27 дугаар зүйл.Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ

Дүгнэвэл, 1.Төслийн 26, 27 дугаар зүйлийн гарчиг адилхан ус цаг уур, орчны үйлчилгээ гэсэн гарчигтай боловч 26 дугаар зүйлд ус цаг уур, орчны үйлчилгээний талаар тусгасан 27 дугаар зүйлд тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг тусгасан байна.

2.Мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээнээс ус цаг уур, орчны үйлчилгээ ялгаатай эсэх нь тодорхойгүй.

3. Өмчийн хэлбэрээс хамаарч “хувийн” гэдэг тодотгол хэрэглэсэн.

4. “Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ” гарчиг зүйлийн доторх зохицуулалттай уялдаа холбоогүй. Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ” гэсэн 27 дугаар зүйлд ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилтийг тусгай зөвшөөрөл авах хүсэлт, түүнд хавсаргах баримт бичиг, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сунгах, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах шаардлагыг тусгасан байх бөгөөд энэ нь тухайн зүйлийн гарчигтай агуулгын хувьд нийцэхгүй байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зөвшөөрлийн зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан зөвшөөрлийг тусгай ба энгийн зөвшөөрөл гэж ангилна, 2 дахь хэсэгт “Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл олгоно.” гэж хуульчилжээ.

Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээний Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөлд тавигдах шалгуурыг хангахгүй байна. Иймд ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах чиг үүргийг гэрээ байгуулах замаар, эсхүл энгийн зөвшөөрөл олгох замаар хуулийн этгээдэд шилжүүлэх үү гэдгийг дахин нягталж үзэх шаардлагатай байна.

Иймд төслийн Хувийн ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээ гэсэн 27 дугаар зүйлийн зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

Иймд Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах зохицуулалтыг төслийн 26 дугаар зүйлд Ус цаг уур, орчны үйлчилгээ, 27 дугаар зүйлд Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ гэж нэрлэсэн нь төөрөгдөлд оруулахаар, хоорондоо уялдаа холбоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн “Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх” 19 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж, мөн “Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Дээрх зохицуулалт нь ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх хууль зүйн үндэслэл нь болно. Иймд төрийн болон хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ гэж ялган зохицуулах шаардлагагүй гэж үзэж байна.

3.5.2.Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой уялдсан эсэх

3.5.2.1.Бусад хуульд хэрэглэсэн нэр томьёо, үг хэллэгийг хэрэглэсэн байдал

1/Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т "усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг ойлгоно гэж хуульчилсан байна. Гэтэл хуулийн төслийн 4.1.4-т "ус судлал" гэж гол, мөрөн, горхи, булаг, шанд, хуурай сайр, мөстөл, мөсөн гол, нуур гэх зэрэг гадаргын усны хувьсал, өөрчлөлтийг судалдаг ухааныг хэлнэ гэж тодорхойлсон байх бөгөөд ингэхдээ усан сан бүхий газарт хамаарах "цөөрөм, тойром, рашаан, намаг"-ийг орхигдуулжээ. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-д заасан "... бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх" гэсэн хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй байна.

Мөн төслийн 4.1.4-т "ус судлал" гэсэн ойлголт нь Усны тухай хуульд заасан "усны нөөц"²⁵, "усны сан бүхий газар"²⁶, "гол, мөрний урсац бүрэлдэх эх"²⁷, "усны эх үүсвэр"²⁸ гэсэн ойлголтуудтай хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.

Ийнхүү хуулийн төсөлд тусгагдсан нэр томьёон ойлгомжгүй байгаа нь хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй төдийгүй тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчил үүсгэх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэхээр байна.

2/Иргэний нисэхийн тухай хуулийн 5.1.2, 12.1.20-д "нисэхийн цаг уур" гэсэн үг хэллэгийг хэрэглэсэн байхад хуулийн төслийн 23.1, 26.6 дахь хэсэг, 26.1.4 дэх заалтад "нислэгийн цаг уур" гэсэн үг хэллэгийг хэрэглэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нийтлэг шаардлагатай нийцэхгүй байна.

3.5.2.2.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж

Бусад хуулийн харилцан уялдаа: Зүйл, хэсэг, заалт сонгосон байдал

Харилцан уялдаа	Сонгосон зүйл, хэсэг, заалт
Хууль хоорондын уялдаа хангагдсан уу	2 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж 2.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1/Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг

²⁵ Усны тухай хууль. 3.1.1."усны нөөц" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг;

²⁶ Усны тухай хууль. 3.1.4."усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг;

²⁷ Усны тухай хууль. 3.1.5."гол, мөрний урсац бүрэлдэх эх" гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг;

²⁸ Усны тухай хууль. 3.1.6."усны эх үүсвэр" гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг;

хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж тусгажээ

Эндээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэгт “усны төлбөрийн хувь, хэмжээг ус, рашааны нөөц, чанар, ашиглалтын хэлбэр, зориулалтыг харгалзан тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, онцлогтой уялдуулан ялгавартай тогтооно” гэж, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт уур амьсгалын мэдээллийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээ асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухай бүр улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ гэсэн хэм хэмжээний зохицуулалт байна. Мөн Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д зааснаар “... байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай” нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарахаар тусгасан байна.

Бусад хуульд нь ус цаг уур, орчны шинжилгээ, мэдээ, мэдээлэлтэй холбогдсон хэм хэмжээ агуулаагүй байх тул хууль тогтоомжийн бүрдэл хэсгээс нийтлэг харилцаа зохицуулж байгаа Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль, Хэмжил зүйн тухай хуулийг хасах шаардлагатай гэж үзлээ.

Санал: төслийн 2.1 дэх хэсгийг “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль²⁹, Байгаль орчныг хамгаалах тухай хууль³⁰, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж өөрчилж, хуулийг нэрийг эш татаж, хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заах шаардлагатай байна.

2/Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “хэмжлийн нэгдмэл байдлыг хангах” зарчмыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд баримтлахаар заасан боловч энэ зарчмыг хэрхэн яаж хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд ямар хэмжих хэрэгсэл, шинжилгээний арга ашиглах, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажлыг хэн гүйцэтгэх, Хэмжил зүйн хуультай хэрхэн уялдах нь тодорхойгүй байна.

Иймд ямар харилцааг нь Хэмжил зүйн хуулиар, ямар харилцааг нь энэ хуулиар зохицуулахыг хуулийн үйлчлэх хүрээнд заах

3/Авто замын тухай /шинэчилсэн найруулга/, Автотээврийн тухай , Агаарын тухай /шинэчилсэн найруулга/, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/, Байгаль орчныг хамгаалах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /шинэчилсэн найруулга/, Барилгын тухай /Шинэчилсэн найруулга/, Дипломат албаны тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай , Иргэний нисэхийн тухай /шинэчилсэн найруулга/, Малчны тухай, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Монгол улсын засгийн газрын тухай, Монгол Улсын Их Хурлын тухай /Шинэчилсэн найруулга/, Музейн тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай /Шинэчилсэн найруулга/, Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Усан замын тээврийн тухай, Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулиудын агуулгаас үзэхэд ус цаг уурын

мэдээ, мэдээлэл улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль орчны аль ч салбарт чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна.

3.5.2.3.Зөвшөөрлийн тухай хууль болон төслийн уялдаа холбоо

Зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох заалт	Төслийн сонгосон зүйл, хэсэг, заалт
2.1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн ангилал 1.Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан доор дурдсанаар ангилна: 1.1.тусгай зөвшөөрөл; 1.2.энгийн зөвшөөрөл. 2.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, ...-д эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, ... нд тусгай зөвшөөрөл олгоно.	27 дугаар зүйл.Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ 27.1.Энэ хуульд заасан ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилт (цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх)-ийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болно.

Дүгнэвэл, Ус цаг уур, орчны үйлчилгээ буюу ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа биш байх тул “тусгай зөвшөөрөл” гэснийг “энгийн зөвшөөрөл болгох”.

1/Зөвшөөрлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зөвшөөрлийн зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшнээс хамааруулан зөвшөөрлийг тусгай ба энгийн зөвшөөрөл гэж ангилна, 2 дахь хэсэгт “Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл олгоно.” гэж хуульчилжээ.

Ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээний Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөлд тавигдах шалгуурыг хангахгүй байна. Иймд ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах чиг үүргийг гэрээ байгуулах замаар, эсхүл энгийн зөвшөөрөл олгох замаар хуулийн этгээдэд шилжүүлэх үү гэдгийг дахин нягталж үзэх шаардлагатай байна.

Иймд төслийн Хувийн ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах үйлчилгээ гэсэн 27 дугаар зүйлийн зохицуулалтыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлагад нийцүүлэх шаардлагатай байна.

2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, уг төслөөр тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн “Тусгай зөвшөөрөл” гэсэн хэсэгт “1.32.ус цаг уурын үйлчилгээ” гэж, мөн хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэсэн хэсэгт “Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус нэмэхээр тусгасан боловч Ерөнхий сайдын дэргэд ажиллах Зөвлөлөөс холбогдох санал дүгнэлтийг аваагүй нь хууль хооронд уялдаа холбоог алдагдуулж байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.” гэж, 5 дахь хэсэгт Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргахаар, 9.3 дугаар зүйлд зөвшөөрөл шинээр бий болгоход дүгнэлт гаргахаар тус тус заасан байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

3.5.2.4.Зөрчлийн тухай хууль болон хуулийн төслийн уялдаа холбоо

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулиар императив шинжтэй буюу хориглосон зохицуулалт тусгагдсан хэдий ч түүнд хамаарах санкц буюу хариуцлагын зохицуулалт Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд байхгүйн улмаас уг заалтын хэрэгжилт хангагдахгүй, практикт хэрэгжих боломжгүй³¹ байгаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр тогтоогдож, холбогдох хууль өөрчлөлт оруулахыг зөвлөсөн байна.

Иймд хууль санаачлагч дээрх хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Зөрчлийн тухай хуульд болон хоорондын холбоог хангах үүднээс Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, энэхүү хуулийн төсөлд хориглосон заалтыг зөрчих болон хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлагыг хүлээлгэхээр тусгасан нь харилцаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлсэн дэвшилтэт өөрчлөлт болжээ.

Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу Зөрчлийн тухай хуультай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос санал авсан байх процессын хэм хэмжээг хэрэгжүүлээгүй байгаа нь хууль хоорондын зөрчилдөөн үүсгэх нэг нөхцөл болох төдийгүй УИХ-д хуулийн төсөл өргөн мэдүүлэх бүрдүүлбэр хангагдаагүй гэж буцаах үндэслэл болохоор байна.

Иймд Хууль тогтоомжийн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал авахаар төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор руу санал хүргүүлэх, ирсэн саналыг хуулийн төсөлд тусгах, хэрвээ 30 хоногийн дотор хариу ирүүлээгүй бол тусгайлсан саналгүй гэж үзэж, УИХ-д өргөн мэдүүлэх бүрдэл хангагдана.

3.5.2.5.Хуулийн төсөл дэх нийгмийн баталгааны зохицуулалт болон бусад хууль тогтоомжийн давхардал, зөрчил

Нэг удаагийн буцалтгүй тусламжийн асуудал

Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/ төсөл
60.1.Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан	25.3.1. Ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;

³¹ Ус цаг уур, орчны шинжилгээний тухай (1994) хуульд хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан, 2025 он

хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно.	
---	--

Дүгнэвэл, Ус цаг уур, орчны шинжилгээний албанд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид хамаарах бөгөөд энэ хуульд “нэг удаагийн буцалтгүй тусламж олгох” зохицуулалт тусгасан эсэхээс үл хамааран Төрийн албаны тухай хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах шаардлагагүй. Хууль тогтоомжийн тухай хуулийн 32.1-д Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ, 32.2-т Хуульд бусад хуулиас эшлэл хийхдээ тухайн заалтыг эх бичвэрээр нь хуулбарлахыг хориглоно” гэж заасан байгааг анхаарах.

Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/ төсөл
125.1.Үйлдвэрлэлийн осол, ... улмаас нас барсан ажилтны ... даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогч ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг дараах хэмжээгээр нэмэгдүүлсэн нөхөн төлбөрийг ажилтан, эсхүл түүний гэр бүлд нэг удаа олгоно: 125.1.2.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол 36 дахин .	10.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно. 10.3.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу тогтоосон хэмжээтэй адил байна. /8.3.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална./	25.3.4. албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд таван жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн ажилтны сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгох;

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 3 дугаар зүйлд даатгуулагч ажлын байранд ажил үүргээ гүйцэтгэж байх үед, ажил олгогч, эрх бүхий этгээд болон албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолт, дайчилгаагаар ажиллаж, ажил үүрэг гүйцэтгэж байх үед, ажлын цагаар ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд ажил үүргээ гүйцэтгэхээр явж байх үед, ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байранд амрах, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед, ажилдаа ирэх, буцах зам, ажил үүргийн дагуу сургалтад оролцох болон Хөдөлмөрийн тухай хуулийн 93.1.1-д заасан амрах,хооллох завсарлагын үед, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах аюулт үзэгдлийн үед, үйлдвэрлэл,

технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж эвдрэх, нурах, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох ослын үед, олон улсын болон улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохоор заажээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 10.1-д Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно, 10.3-т нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон хэмжээтэй адил байна гэж хуульчилжээ.

Гэтэл төслийн 25.3.4-т албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд таван жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн ажилтны сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно гэж заасан нь хууль хоорондын зөрчлийг үүсгэж байна.

Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд түүний гэр бүлд нэг удаа тэтгэмж олгох асуудал Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн зохицуулах харилцаа биш байна.

3.5.2.6.Иргэний хууль болон хуулийн төслийн давхардал

Иргэний хууль	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/ төсөл
498.1.Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.	25.5. Ажилтан албан үүргээ зохих журмын дагуу биелүүлэх явцдаа бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан бол тухайн хохирлыг төр хариуцна.
498.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.	

Дүгнэвэл, Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад бусдад гэм хор учруулсан бол төрийн байгууллага уг гэм хорыг арилгахаар Иргэний хуульд заасан тул энэ хуулийн төсөлд энэ зохицуулалтыг хуулбарлан тусгах шаардлагагүй.

Иргэний хуулийн “Байгууллага, албан тушаалтан бусдад гэм хор учруулсны хариуцлага” гэсэн 498 дугаар зүйлд албан хаагчийн буруутай үйлдлээс бусдад гэм хор учирсан бол тухайн байгууллага түүнийг арилгах, хохирогч өөрөө санаатай буюу илтэд болгоомжгүй хандсан, эсхүл хууль тогтоомжид нийцсэн арга хэрэгслээр үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт нь гэм хор учирсан бол байгууллагыг хариуцлагаас чөлөөлөх, өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулахаар зохицуулсан байна.

Иймд ажилтны албан үүргээ зохих журмын дагуу биелүүлэх явцад бусад учруулсан гэм хорыг арилгах асуудал нь энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй, мөн

Иргэний хуулиар зохицуулсан асуудлыг энэ хуулийн төсөлд хуулбарлах шаардлагагүй байна.

Хуулийн төслийн 25.3.7.гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал хамрагдах .

Дөрөв.ДҮГНЭЛТ

Хуулийн төсөл хэрэгжсэнээр улсын хэмжээнд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээ бүрдэж, гамшгийн эрт сэрэмжлүүлгийн чадавх сайжрах, хөдөө аж ахуй, усны нөөц, байгаль орчны менежментэд шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргалт нэмэгдэх, олон улсын байгууллагын стандарт, шаардлагад нийцэх нөхцөл бүрдэх, уур амьсгалын өөрчлөлтийн мониторингийн үндэсний чадавх бэхжихэд тус нэмэр болно. Хуулийн үндэсний аюулгүй байдал, гамшгийн эрсдэлийн бууралт, иргэдийн аюулгүй байдал, хөдөө аж ахуйн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой.

4.1.Зорилгод хүрэх байдлын үнэлгээний дүгнэлт

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6, 7, 8 дугаар зүйл болон тэдгээртэй холбоотой зохицуулалтууд нь Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний тогтолцоог боловсронгуй болгох бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Төсөлд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний эрх зүйн үндсийг тодорхой болгож, сүлжээний хөгжлийн 10 жилийн ерөнхий төлөвлөгөөтэй байх, станцын нягтрал, байршил, ангилал, ажиглалтын хөтөлбөрийг урт хугацаанд төлөвлөх, ажиглалтын станцуудыг төрөлжүүлэн хөгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, инновац, дэвшилтэт технологийг дэмжих зэрэг шинэ зохицуулалтыг тусгасан нь олон улсын жишиг, ялангуяа Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмж болон Япон, БНСУ, БНХАУ-ын ус цаг уурын байгууллагуудын туршлагатай нийцэж байна.

Түүнчлэн улсын сүлжээний станцуудыг цаг уурын, ус судлалын, орчны хяналт-шинжилгээний, хөдөө аж ахуйн цаг уурын, дээд агаар мандлын, радарын, мал аж ахуйн цаг уурын, нарны цацраг судлалын болон тусгай зориулалтын гэсэн төрөлтэй байхаар ангилсан нь гамшгийн эрсдэлийн удирдлага, усны нөөцийн менежмент, хөдөө аж ахуй, байгаль орчны мониторинг, эрт сэрэмжлүүлгийн тогтолцооны чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохистой шийдэл болсон байна.

Хэдийгээр Монгол Улсын ажиглалтын сүлжээний нягтаршил олон улсын жишигтэй харьцуулахад харьцангуй доогуур хэвээр байгаа боловч хуулийн төсөлд тусгасан төлөвлөлт, сүлжээний өргөтгөл, хувийн хэвшлийн оролцоог дэмжих зохицуулалтууд нь энэхүү сул талыг үе шаттайгаар бууруулах боломжийг бүрдүүлж байна.

Иймд хуулийн төсөлд тусгасан дээрх зохицуулалтууд нь ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний хүртээмж, чанар, нарийвчлалыг сайжруулах, аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах, эрт сэрэмжлүүлгийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хүн ам, мал аж ахуй, эдийн засагт учирч болох хохирлыг бууруулах замаар хуулийн төслийн зорилгод хүрэхэд бодитой хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

Гэсэн хэдий ч зохицуулалтын ойлгомжтой байдал, хэрэгжилтийн механизм, санхүүжилтийн эх үүсвэр, байгууллага хоорондын уялдаа холбоо болон практикт хэрэгжих боломжийг цаашид нарийвчлан боловсруулж, холбогдох үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтээр илэрсэн асуудлыг тусган сайжруулах шаардлагатай байна.

4.2. Ойлгомжтой байдлын үнэлгээний дүгнэлт

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн зорилт, нэр томьёо, зохицуулалтын агуулга, бүтэц, найруулгын хувьд тодорхой бус, давхардсан болон зөрчилтэй зохицуулалт цөөнгүй байна.

Тухайлбал, хуулийн зорилтод тусгасан “хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах”, “нийгэм, эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зэрэг үр дүнгийн шинжтэй зорилгууд нь хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтгүй, хэрэгжилтийг бодитой үнэлэх боломж хангалтгүй байна. Мөн “шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээлэл” зэрэг ойлголтын агуулга тодорхойгүй бөгөөд хэрэгжилтийн явцад нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж болзошгүй байна.

Хуулийн төсөлд нэр томьёог жигд бус хэрэглэсэн, нэг ойлголтыг олон янзаар томьёолсон, эсхүл нэг нэр томьёогоор өөр өөр ойлголт илэрхийлсэн тохиолдол түгээмэл байна. Үүнд “ус цаг уур”, “ус, цаг уур”, “усан мандал”, “станц”, “ажиглалтын станц”, “шинжилгээний талбай” зэрэг нэр томьёоны хэрэглээ багтаж байгаа бөгөөд энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн нэр томьёоны нэгдмэл байдлыг хангах шаардлагад бүрэн нийцэхгүй байна.

Түүнчлэн хуулийн төсөлд тодорхойлсон зарим нэр томьёо нь цаашдын зохицуулалтад ашиглагдаагүй, эсхүл зөвхөн салбарын мэргэжлийн хүрээнд хэрэглэгдэх шинжтэй байхад хуулийн түвшинд тайлбарлан тусгасан байна. Энэ нь хуулийн агуулгыг хэт дэлгэрүүлж, хэрэглэгчдэд ойлгомжгүй байдал үүсгэх эрсдэлтэй байна.

Мөн зарим зохицуулалтын хүрээ, хэрэгжүүлэх журам, шалгуур нөхцөл тодорхойгүй орхигдсон нь эрх зүйн хийдэл үүсгэхээр байна. Ялангуяа ажиглалт, хэмжилтийн цэгийн эрх зүйн статус, үйл ажиллагааны зохион байгуулалт, хувийн хэвшлийг дэмжих механизм, төлөвлөгөө шинэчлэх үндэслэл, хувийн өмч ашиглах нөхцөл зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Үүнээс гадна товчлол буруу хийсэн, нэр томьёоны агуулгын давхардал болон зөрчил үүсгэсэн, зарим заалтын найруулга ойлгомжгүй байгаа нь хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах эрсдэлтэй гэж үзэв.

Иймд хуулийн төслийн нэр томьёоны хэрэглээг нэгдмэл болгох, ойлгомжгүй болон давхардсан зохицуулалтыг цэгцлэх, зорилт болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, эрх зүйн хийдэл үүсгэж буй асуудлуудыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

4.3. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээний дүгнэлт

Хуулийн төслийн 6, 8, 14 дүгээр зүйлүүдийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхэд төсөл нь төрийн байгууллагын чиг үүргийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, эсхүл иргэн, хуулийн этгээдэд хэт их ачаалал, хүндрэл үүсгэсэн гэж үзэхээргүй байна. Харин ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний бүтэц, үйл ажиллагааг орчин үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, төрөлжсөн ажиглалтын станцын эрх зүйн үндсийг тодорхой болгох, мэдээллийн нэгдсэн сан, системийг бүрдүүлэх замаар салбарын үйл ажиллагааны үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтуудыг тусгажээ.

Төслөөр улсын сүлжээний бүрэлдэхүүн, станцын төрөл, ажиглалт хэмжилтийн тогтолцоог нарийвчлан зохицуулснаар цаг агаар, уур амьсгал, орчны аюулт үзэгдлийг эрт илрүүлэх, сэрэмжлүүлэх, эрсдэлийг бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд

хөрөнгийг хамгаалах нөхцөл сайжрах боломж бүрдэнэ. Ялангуяа хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэх, зуд, ган, үер зэрэг гамшгийн эрсдэлийг бууруулах, үйлдвэрлэл төлөвлөлтийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Мөн Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн системийг бий болгох зохицуулалт нь мэдээллийн чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, төрийн цахим шилжилтийг дэмжих, эрт сэрэмжлүүлгийн тогтолцоог бэхжүүлэх стратегийн ач холбогдолтой гэж үзэж байна.

Хэдийгээр станцын төрөл, сүлжээний хамрах хүрээ өргөжихийн хэрээр улсын төсөвт тодорхой хэмжээний нэмэлт зардал шаардагдах боловч уг зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гамшгийн эрсдэл, эдийн засгийн хохирлыг бууруулах, байгаль орчны мониторингийг сайжруулах, олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтыг хэрэгжүүлэх зэрэг урт хугацааны үр өгөөж нь гарах зардлаа нөхөхүйц ач холбогдолтой байна.

Иймд хуулийн төслийн 6, 8, 14 дүгээр зүйлүүдэд тусгасан улсын сүлжээ, төрөлжсөн станцууд болон ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сангийн талаарх зохицуулалтууд нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх эерэг үр нөлөө өндөртэй, хэрэгжих боломжтой бөгөөд хүлээн зөвшөөрөгдөх түвшний зохицуулалт гэж үзэв.

4.4. Практикт хэрэгжих байдлын үнэлгээний дүгнэлт

Хуулийн төслийн практикт хэрэгжих байдлыг үнэлэхэд ус цаг уур, орчны үйлчилгээ эрхлэх, салбарын ажилтнуудад мөнгөн тэтгэмж болон нэмэгдэл олгох, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй холбоотой зохицуулалтуудыг сонгон авч шинжиллээ.

Үнэлгээний үр дүнгээс үзэхэд хуулийн төслийн 27 дугаар зүйлд тусгасан хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ эрхлэх зохицуулалт нь төрөөс үзүүлэх зарим үйлчилгээг хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн дарамтыг бууруулах ач холбогдолтой байна. Гэвч энэхүү үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр эрхлүүлэхээр зохицуулсан боловч Зөвшөөрлийн тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулахтай холбоотой хуульд заасан зөвшөөрлийн зөвлөлийн дүгнэлт аваагүй байгаа нь уг зохицуулалтыг шууд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Иймд холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг бүрэн шийдвэрлэсний дараа хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хуулийн төслийн 25.3.2-т заасан салбартаа тасралтгүй ажилласан ажилтанд таван жил тутам зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох зохицуулалт нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, орон нутагт ажиллах мэргэжилтнийг дэмжих бодлогын ач холбогдолтой байна. Мөн боловсрол, соёл, төрийн алба зэрэг бусад салбарт ижил төстэй зохицуулалт хэрэгжиж байгаа нь практик хэрэгжих боломжтойг харуулж байна. Гэвч төсөвт нэмэлт ачаалал үүсгэх тул Төсвийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн санхүүгийн тооцооллыг хийж, хэрэгжих хугацааг үе шаттайгаар буюу дараагийн төсвийн жилээс эхлүүлэх нь зүйтэй байна.

Харин төслийн 25.3.3-т заасан ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдлийн үед ажилласан ажилтанд цалин хөлсийг гурав дахин нэмэгдүүлэн олгох зохицуулалт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн болон гамшгаас хамгаалах хууль тогтоомжид нийцэхгүй байна. Одоогийн эрх зүйн зохицуулалтаар ийм нөхцөлд цалин нэмэгдүүлэх бус, харин томилолтын зардлыг нэмэгдүүлэн олгох зохицуулалт үйлчилж байгаа тул энэхүү заалт практикт хэрэгжих боломжгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Түүнчлэн төслийн 25.3.5, 25.3.6-д тусгасан хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлтэй болон амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй нөхцөлд ажилласны нэмэгдэл, урамшууллын асуудал нь Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний журмаар зохицуулагдах харилцаанд хамаарч байна. Иймээс эдгээр асуудлыг салбарын тухай хуульд тусгайлан давхардуулан зохицуулах шаардлагагүй бөгөөд хэрэгжилтийн хувьд хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байна.

Иймд хуулийн төслийн практикт хэрэгжих байдлын үнэлгээгээр салбарын үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой зарим зохицуулалт хэрэгжих боломжтой гэж үзэгдэж байгаа боловч тусгай зөвшөөрөл шинээр бий болгох, төсөвт нэмэлт зардал үүсгэх болон хөдөлмөрийн харилцаатай давхардсан зохицуулалтуудыг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх, санхүүгийн болон эрх зүйн нөхцөлийг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Иймээс хуулийн төслийн зарим заалтыг хэрэгжих хугацаа, эрх зүйн уялдаа, төсвийн нөлөөллийн тооцоотой нь уялдуулан боловсронгуй болгох нь зүйтэй гэж дүгнэв.

4.5.Харилцан уялдааг үнэлсэн байдлын дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхэд төслийн зарим зохицуулалт нь хуулийн дотоод бүтэц, нэр томьёоны хэрэглээ, бусад хууль тогтоомжтой нийцэл, давхардал болон зөвшөөрлийн тогтолцоотой уялдах байдал хангалтгүй байгаа нь тогтоогдлоо.

Нэгдүгээрт, төслийн хэмжээнд “мэдээ”, “мэдээлэл”, “ус цаг уур, орчны үйлчилгээ”, “ус цаг уур, орчны мэдээлэл”, “нийтийн хэрэгцээний мэдээ”, “хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ” зэрэг ойлголт, нэр томьёог ялгамжгүй, харилцан давхардсан байдлаар хэрэглэсэн нь зохицуулалтын зорилго, хамрах хүрээ, эрх зүйн үр дагаврыг ойлгоход хүндрэл үүсгэж байна. Ялангуяа төслийн 26, 27 дугаар зүйлүүдийн гарчиг болон дотоод агуулга хоорондоо бүрэн нийцэхгүй, үйлчилгээний харилцаа болон зөвшөөрлийн харилцааг нэгтгэн зохицуулсан нь хуулийн бүтцийн логик дарааллыг алдагдуулсан байна.

Хоёрдугаарт, төслийн зарим нэр томьёо, тодорхойлолт нь Усны тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид хэрэглэсэн нэр томьёотой нийцээгүй, эсхүл тэдгээртэй хэрхэн уялдах нь тодорхойгүй байна. Энэ нь хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдах, тайлбарын зөрүү гарах, улмаар практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй байна.

Гуравдугаарт, төслийн 27 дугаар зүйлээр ус цаг уур, орчны үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор тусгасан нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох үндэслэл, шалгууртай бүрэн нийцэхгүй байна. Иймд уг үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн бус, энгийн зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх боломжийг дахин нягтлах шаардлагатай байна. Түүнчлэн зөвшөөрөл шинээр бий болгохтой холбоотой хуульд заасан санал, дүгнэлт авах ажиллагаа бүрэн хангагдаагүй байгаа нь хууль хоорондын уялдаанд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Дөрөвдүгээрт, төслийн зарим зохицуулалт нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Иргэний хууль зэрэг хуулиудаар нэгэнт зохицуулагдсан харилцааг давтан тусгасан, зарим тохиолдолд зөрчил үүсгэхээр байна. Ялангуяа ажилтны нийгмийн баталгаа, нөхөн төлбөр, тэтгэмж, гэм хорын хариуцлагатай холбоотой заалтуудыг дахин зохицуулах нь хууль тогтоомжийн давхардал үүсгэх эрсдэлтэй бөгөөд эшлэлийн аргаар зохицуулах нь зүйтэй байна.

Тавдугаарт, төслийн хэрэгжилтийг хангах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага зөв тодорхойлогдсон боловч холбогдох байгууллагуудаас хуульд заасан журмын дагуу санал, дүгнэлт аваагүй байгаа нь хууль тогтоох ажиллагааны процессын шаардлагыг бүрэн хангаагүй гэж үзэх үндэслэл болж байна.

Иймд хуулийн төсөл нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нийтлэг зорилготой нийцэж байгаа боловч нэр томъёоны нэгдмэл байдал, дотоод бүтэц, зөвшөөрлийн зохицуулалт, бусад хууль тогтоомжтой нийцэл, давхардал, эшлэлийн хэрэглээ болон хууль тогтоох ажиллагааны процессын шаардлагын хүрээнд нэмэлт сайжруулалт хийх шаардлагатай байна. Дээрх асуудлыг шийдвэрлэснээр төслийн дотоод болон гадаад харилцан уялдаа хангагдаж, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхээр байна.

Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хуулийн төслийн Хүний эрх, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг үнэлж хавсаргав.

Нэгтгэн дүгнэвэл, Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хуулийн төслийн практикт хэрэгжих байдлын үнэлгээнээс үзэхэд төсөл нь ус цаг уур, орчны мэдээллийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн эерэг ач холбогдолтой байна.

Гэвч хувийн ус цаг уурын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт нь Зөвшөөрлийн тухай хуульд шаардлагатай өөрчлөлт, холбогдох зөвлөлийн дүгнэлтгүй байгаа тул шууд хэрэгжих эрх зүйн үндэслэл бүрэн бүрдээгүй байна. Мөн ажилтанд олгох мөнгөн тэтгэмжийн зохицуулалт хэрэгжих боломжтой боловч төсөвт нэмэлт ачаалал үүсгэх тул үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай. Харин онц аюултай үзэгдлийн үед ажилласан ажилтны цалин хөлсийг гурав дахин нэмэгдүүлэх болон хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлтэй холбоотой зарим зохицуулалт нь хүчин төгөлдөр хууль тогтоомжтой давхцах, нийцэхгүй байх шинжтэй тул дахин боловсронгуй болгох шаардлагатай байна.

Шинэ станц байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах, засвар үйлчилгээ, программ хангамж, холбоо дамжуулалт, хүний нөөцийн зардал өсөх магадлалтай. Ялангуяа, радарын станц, дээд агаар мандлын станц, автомат ажиглалтын систем, лабораторийн тоног төхөөрөмж өндөр өртөгтэй байна. Мөн, хүний нөөцийн дутагдал төрөлжсөн станцуудыг ажиллуулахад тулгарч болзошгүй.

Иймээс хуулийн төсөл нь нийтлэг агуулгын хувьд практикт хэрэгжих боломжтой боловч зарим зохицуулалтын эрх зүйн уялдаа, төсвийн тооцоо, хэрэгжүүлэх механизмыг нарийвчлан боловсруулж, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. Улаанбаатар, 1992.
2. Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хууль. Улаанбаатар, 1997.
3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.
4. Зөвшөөрлийн тухай хууль. Улаанбаатар, 2022.
5. Гамшгаас хамгаалах тухай хууль (шинэчилсэн найруулга). Улаанбаатар, 2017.
6. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга). Улаанбаатар, 2021.
7. Төрийн албаны тухай хууль. Улаанбаатар, 2017.
8. Төсвийн тухай хууль. Улаанбаатар, 2011.
9. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. Улаанбаатар, 1993.
10. Боловсролын ерөнхий хууль. Улаанбаатар, 2023.
11. Соёлын тухай хууль. Улаанбаатар, 2021.
12. Шүүх шинжилгээний тухай хууль. Улаанбаатар, 2022.
13. Иргэний хууль. Улаанбаатар, 2002.

Хоёр. Засгийн газрын тогтоол, журам

14. Засгийн газрын 2023 оны тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”.
15. Засгийн газрын 2024 оны тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”.
16. Засгийн газрын тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”.
17. Засгийн газрын тогтоолоор баталсан “Аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчид мөнгөн тэтгэмж олгох журам”.
18. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”.

Гурав. Үндэсний тайлан, статистик мэдээлэл

19. Цаг уур, орчны шинжилгээний газар. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын үйл ажиллагааны тайлангууд. Улаанбаатар.
20. Онцгой байдлын ерөнхий газар. 2024 оны гамшиг, аюулт үзэгдлийн статистик мэдээлэл. Улаанбаатар, 2025.
21. Үндэсний статистикийн хороо. Хөдөө аж ахуй, байгаль орчин, гамшгийн статистикийн эмхэтгэлүүд.
22. Монгол Улсын Засгийн газар. Зудын гамшгийн үр дагавар, эдийн засгийн хохирлын үнэлгээний тайлангууд.

Дөрөв. Олон улсын байгууллагын тайлан, судалгаа

23. World Meteorological Organization. *Early Warnings for All Initiative*. Geneva.
24. World Meteorological Organization. *State of the Climate in Asia*.
25. Intergovernmental Panel on Climate Change, *Sixth Assessment Report (AR6)*, Geneva, 2021–2023.
26. World Bank. *The Economics of Early Warning Systems* болон гамшгийн эрсдэлийн удирдлагын судалгаанууд.
27. United Nations Office for Disaster Risk Reduction. *Early Warning Systems and Disaster Risk Reduction Reports*.
28. United Nations Development Programme. Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийн үнэлгээний судалгаанууд.

Тав. Стандарт

29. MNS 5080:2023. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавигдах шаардлага.
30. MNS 4990:2023. Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжилтэд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

Зургаа. Гадаад орны туршлага

31. Japan Meteorological Agency. *Early Warning and Disaster Risk Reduction Reports*.
32. Korea Meteorological Administration. *Weather Warning Services and Climate Information Reports*.
33. Typhoon Hagibis-ийн дараах үнэлгээний тайлангууд болон гамшгийн эрсдэлийн удирдлагын судалгаанууд.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх				
	1.1.1	Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Цаг агаарын урьдчилсан, сэрэмжлүүлэг болон бодит мэдээлэл, орчны бохирдол, төлөв байдлын талаарх мэдээллийг авах боломж нь үргэлжилнэ.
	1.1.2	Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг гаргасан байгууллага онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны байгууллага, иргэдэд хүргэх тул аль бүлэгт давуу байдал үүсгэхгүй.
	1.1.3	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг арилгахын тулд авч буй түр, тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх		Үгүй	Цаг агаарын урьдчилсан, сэрэмжлүүлэг болон бодит мэдээлэл, орчны бохирдол, төлөв байдлын талаарх мэдээллийг Үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны байгууллага, иргэдэд хүргэх тасралтгүй үйл ажиллагаа хэрэгжих тул бүх иргэд тэгш эрхтэй.
	1.2. Оролцоог хангах				
	1.2.1	Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Ус цаг уурын станцын төрөл, нягтрал нэмэгдсэнээр иргэдийн гамшгийн эрсдэлээс хамгаалагдах оролцоо нэмэгдэнэ.

	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Орон нутгийн онцлог, байгаль ус цаг уур, орчны аюултай үзэгдлээс эрт сэрэмжлүүлэх чиглэлийг баримталж байна.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Амьдрал ахуй, аж ахуйгаа удирдахад ус цаг уурын мэдээ мэдээллээр шуурхай хангагдаж, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгө, амь насаа хамгаалах, хохирол багатай даван туулахад ахиц дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмжид нийцүүлэн ус цаг уурын шинжилгээ хийх станцуудын төрөл, нягтрал, үйл ажиллагаандаа баримтлах хөтөлбөртэй байх, автоматжуулсан багаж, систем, дижитал болон зайнаас тандах технологи, хиймэл оюун ухаанд суурилсан арга, аргачлалыг нэвтрүүлэх, нутагшуулах замаар хүний оролцооны алдааг бууруулах, өгөгдлийн чанар, хүртээмжийг сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор олон улсын стандарт болон сүлжээ, мэдээлэл солилцоотой нийцүүлэг хөгжүүлнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг болон орчны чанарын талаарх мэдээллийг ус цаг уур,

				орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргах ба Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны баталгаажуулаагүй урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэгийг олон нийтэд түгээхийг хориглох, мөн Баталгаажуулаагүй багаж, тоног төхөөрөмжийн мэдээ, мэдээллээр үйлчигээ үзүүлэхийг хориглох заалтуудыг тусгаж, хариуцлагыг холбогдох хуулиар зохицуулна..
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хүний эрхийг хязгаарлах зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	3.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Жендэрийн хувьд ялгаварлал үүсгэхгүй.
	3.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлнэ.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар		1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Зохицуулалт нь ус цаг уур, орчны мэдээ, мэдээллээр хангах харилцааг тодорхой болгож байгаа бөгөөд зах зээлд ялгавартай нөхцөл үүсгэхгүй.
		1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх			Ус цаг уур, орчны шинжилгээний станцуудыг олон улсын

	эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		байгууллагын зөвлөмж, стандартад нийцсэн хөтөлбөр, нягтралд хүргэхийг зорьж байгаа ба төрөөс ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын үйлчилгээний инновац, судалгаа, дэвшилтэт технологи хөгжүүлэх үйл ажиллагаа болон хувийн хэвшлийн оролцоог дэмжих тул мэдээ мэдээллийн чанар, хүртээмж, нарийвчлал сайжрах, улмаар хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлэх боломжтой.
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн баталж, хэрэгжүүлэх, тайлагнах, тэдгээрийг мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан тул ил тод байдал хангах үйл явц сайжирна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Эрт сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх болон бодит мэдээллийн хүртээмж, хурд, нарийвчлал сайжрах тул хэрэглэгчийн цаг агаар, орчны нөлөөллөөс эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөө хамгаалах шийдвэр гаргах боломж нэмэгдэнэ.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Мэдээ мэдээллийн шуурхай байдал хангагдсанаар эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөө

				нэмэгдэж, гамшгийн эрсдэл буурна.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Энэ хуульд заасан ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилтийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 5 жилийн хугацаагаар эрхэлж болохоор заасан нь хуулиар тавьсан шаардлагыг хангаж байгаа ямар ч аж ахуйн нэгжид нээлттэй байхаар зохицуулсан.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Ус цаг уур, орчны хяналтын салбарт хувийн хөрөнгө оруулалт орж, төвлөрөл саарах, үйл ажиллагааны шуурхай байдал хангагдана.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм		ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилтийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд нарийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тул станц барих, шинэчлэх, шинжилгээ хийх зэрэгт шинээр зардал үүснэ.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ус цаг уур, орчны шинжилгээний улсын төлөвлөгөөний хүрээнд хийгдэх тул санхүүжилтийн эх үүсвэр олж авах нөлөө үзүүлнэ.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм		Ус цаг уур, орчны шинжилгээний улсын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх тул станц барьж байгуулах, шинэчлэл хийх зэрэгт бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт өснө.

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Хязгаарлалт үүсгэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд сөрөг дарамт үүсгэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм		Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн боловсруулсан ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг мэдээллийн нэгдсэн системд нийлүүлэх, эрсдэлийн удирдлага, тайлагналтай холбоотой тодорхой шаардлага нэмэгдэнэ.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Өмчлөх эрхэд шууд нөлөөлөхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Өмчлөх эрхэд нөлөөлөхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Нөлөөлөл байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		Урт хугацааны санхүүжилт нэмэгдсэнээр инновац, дэд бүтцийн төсөл дэмжигдэнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		Автоматжуулсан багаж, систем, дижитал болон зайнаас тандах технологи, хиймэл оюун ухаанд суурилсан арга, аргачлалыг нэвтрүүлэх, нутагшуулах замаар хүний оролцооны алдааг бууруулах, өгөгдлийн чанар, хүртээмжийг

				сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор олон улсын стандарт болон сүлжээтэй нийцүүлэн 10 жилийн хугацаатай төлөвлөж хөгжүүлэх тул технологийн шинэчлэл хурдасна.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ус цаг уурын салбарт оруулсан хөрөнгө оруулалтын 1 доллар тутам 4-10 долларын ашиг тус өгдөг гэдгийг олон улсын судалгаа, гадаад улсуудын сайн туршлагаар тогтоосон тул хүний амь нас, эд хөрөнгө, эдийн засагт эерэг нөлөөтэй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		Монгол орны хэмжээнд ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээд, байгууллагыг хангах ба олон улстай мэдээлэл солилцох харилцааг өргөжүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Сөрөг нөлөөлөл байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эрт сэрэмжлүүлэг гамшгийн улмаас учрах хохирлыг 30 хувиар бууруулдаг болохыг ДЦУБ болон холбогдох бусад олон улсын байгууллага тогтоосон эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Станцуудын төрөл, тоо, нягтралыг нэмснээр орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх			
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хувийн станцуудад ЖДҮ-ийн санхүүжилтийн боломж нэмэгдэнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ус цаг уур, орчны шинжилгээний улсын төлөвлөгөөгөөр 10 жилийн туршид хийгдэх тул жил бүр тодорхой хэмжээний ачаалал үүсэх магадлалтай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм		Судалгаанд үндэслэн боловсруулсан 10 жилийн төлөвлөгөөнд туссан тохиолдолд станц нэмэгдэнэ.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбоотой чиг үүргийн хүрээ нь өргөжнө. Түүнчлэн улсын төлөвлөгөө болон нэгдсэн сангийн үйл ажиллагаа, бүрдүүлэлт, ашиглах асуудлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцахаар шинэ чиг үүрэг нэмэгдэж байгаа боловч одоогийн түвшинд хийж байсан ажлыг цахимжуулах тул шуурхай байдал хангагдана.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эрт сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх болон бодит мэдээллийн шуурхай, нарийвчлалтай байдал сайжирч, гамшгийн хохирол багасч, эдийн засгийн

				өсөлтөд эергээр нөлөөлнө. Мөн станцын төрөл, тоо, нягтрал, үйлчилгээний төрөл нэмэгдсэнээр ажлын байр нэмэгдэх ба ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа сайжирна.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Хөрөнгө оруулалт, даатгал, санхүүгийн нөхцөл сайжирч, зах зээлтйн тогтвортой байдал сайжирна.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Эсрэгээрээ дунд, урт хугацаанд гамшгийн улмаас үүдэлтэй инфляц буурах нөхцөл бүрдэнэ.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд		Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл		1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	тийм			станцын төрөл, тоо, нягтрал, үйлчилгээний төрөл нэмэгдсэнээр ажлын байр нэмэгдэнэ.
		1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй		Аливаа цомхотгол байхгүй
		1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм			Гамшгийн болзошгүй болон бодит эрсдэлээс амь нас, эд хөрөнгөө хамгаалж, аж ахуйгаа хохирол багатай эрхлэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ялангуяа малчид, тариаланчдад эерэг нөлөө үзүүлнэ.

	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Насны ялгаатай нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ажлын чанар, стандартад нөлөөгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Шаардлагагүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		Ус цаг уур, орчны хяналт шинжилгээг олон улсын стандартад нийцүүлснээр технологийн шинэчлэл хийгдэнэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Орон нутгийн санхүүжилтийг нэмэгдүүлэх нь бүс нутгийн ялгааг бууруулна.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөөгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ялгавартай нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун ёс	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөл бага.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газар болон холбогдох байгууллагын хяналтын чиг үүрэг тодорхой хэмжээнд нэмэгдэнэ.

	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Шууд нөлөөлөл бага.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрх хөндөгдөхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Олон улсын стандартад нийцүүлснээр мэдээллийн нарийвчлал, шуурхай байдал, үйлчилгээний чанар сайжирна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм		Шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой мэдлэг, дадлага хийх сургалтад хамрагдах шаардлага үүснэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм		Хүний нөөцийг бэлтгэх тоо хэмжээг өсгөх шаардлага гарна.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

Хавсралт 2

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ /1997 он/ БОЛОН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

2026.06.07.

УБ хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ	УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
1 дүгээр зүйл.Хуулийн зорилт	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй, орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй зохицон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ус цаг уур, орчны хяналт шинжилгээг тасралтгүй явуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ, мэдээллээр хувь хүн, хуулийн этгээд (цаашид “хэрэглэгч” гэх)-ийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж	2 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж
2.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	2 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж 2.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль , энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ
	3.1. Энэ хуулиар ус цаг уур, орчин, уур амьсгалын хяналт шинжилгээ, мэдээллийн үйлчилгээтэй холбогдох харилцааг зохицуулна.
3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:	4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
	4.1.1.“ус цаг уур” гэж гадаргын ус судлал болон цаг уур судлалын ухааныг хамтад нь;
	4.1.2.“цаг агаар” гэж агаар мандлын төлөв байдал, агаар мандалд ажиглагддаг байгалийн үзэгдлийн цогцыг;
	4.1.3 “цаг уур” гэж дэлхийн агаар мандлыг судалдаг шинжлэх ухааны салбарыг;
	4.1.4.ус судлал” гэж гол, мөрөн, гөрхи, булаг, шанд, хуурай сайр, мөстөл, мөсөн гол, нуур гэх зэрэг

	гадаргын усны хувьсал, өөрчлөлтийг судалдаг ухааныг;
3.1.1."Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ" гэж тогтоосон хөтөлбөрийн дагуу хийн мандал, усан мандал, чулуут мандал , шим мандлын байгалийн төлөв байдлын үзүүлэлтүүдийг хэмжин тодорхойлж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зохих шийдэл гаргах үйл ажиллагааг;	4.1.5."ус цаг уур, орчны хяналт шинжилгээ" гэж хийн мандал, усан мандал, шим мандлын байгалийн төлөв <u>байдал, хувьсал өөрчлөлтийн үйл явц, үзэгдэл, байгаль орчны төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг</u> нэгдмэл арга зүй, хөтөлбөрөөр ажиглаж , хэмжиж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зохих шийдэл гаргах үйл ажиллагааг;
	4.1.6."уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ" гэж уур амьсгалын өөрчлөлтийг урт хугацаанд ажиглах, үнэлэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг;
3.1.2."Уур амьсгалын нөөц" гэж нарны цацраг, хур тунадас, агаар, хөрсний чийг, дулаан хангамж, усны хүрэлцээ, салхи, усны эрчим зэрэг хүний амьдралын хэрэгцээг хангахад ашиглаж болох байгалийн чадавхийг	
	4.1.7.хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалт" гэж мал аж ахуй, таримал ургамал, бэлчээрийн ургамлын, хөрсний төлөв байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг ажиглах, хэмжих үйл ажиллагааг;
3.1.3."Урьдчилсан мэдээ" гэж ус цаг уур, орчны төлөв байдлыг хэдэн цаг, хоног, сар, улирлын өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан тодорхойлж гаргасан мэдээг;	4.1.8."урьдчилсан мэдээ" гэж ус цаг уур, орчны төлөв байдал, хувьсал, өөрчлөлтийн үйл явцыг хэдэн цаг, хоног, сар, улирлын өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан тооцоолж гаргасан мэдээллийг;
3.1.4."Урьдчилан сэргийлэх мэдээ" гэж ус цаг уурын үзэгдэл, орчны бохирдол, цацраг идэвхжилт зэрэг нь хүн ам, байгаль орчин, эдийн засагт ихээхэн хохирол учруулах хэмжээнд хүрч болзошгүй тухай урьдчилан тодорхойлж гаргасан мэдээг;	4.1.9."сэрэмжлүүлэг" гэж ус цаг уурын үзэгдэл, орчны бохирдол нь хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд эрсдэл учруулж болзошгүй тухай урьдчилсан мэдээг;
3.1.5."Нийтийн хэрэгцээний мэдээ" гэж хүн амын өргөн хэрэгцээнд зориулан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээн зарлаж байгаа ус цаг уур, орчны мэдээг;	4.1.10. "нийтийн хэрэгцээний мэдээ" гэж олон нийтэд зориулан нийтэд <u>нээлттэйгээр түгээдэг</u> ус цаг уур, орчны мэдээллийг;

3.1.6."Тусгай хэрэгцээний мэдээ" гэж хөдөө аж ахуй, зам тээвэр, эрчим хүч, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тодорхой салбарын онцлогийг харгалзсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар гаргаж байгаа ус цаг уур, орчны мэдээг.	4.1.11. "тусгай хэрэгцээний мэдээ" гэж <u>тодорхой хэрэглэгчийн захиалгаар боловсруулан гаргасан</u> ус цаг уур, орчны мэдээллийг;
	4.1.12. "ус цаг уурын гаралтай аюултай үзэгдэл" гэж хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учруулж, хүрээлэн буй орчин, амьдралын нөхцөл байдал болон нийгэм-эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх ус цаг агаарын онцгой үзэгдлийг;
	4.1.13. "уур амьсгал" гэж цаг агаарын олон жилийн статистик дунджаар тодорхойлогдох төлөв байдлыг;
	4.1.14. "уур амьсгалын өөрчлөлт" гэж байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр уур амьсгалд урт хугацаанд гарч буй хэлбэлзлийг;
	4.1.15. "урт хугацааны урьдчилсан төлөв" гэж сар болон түүнээс дээш хугацааны уур амьсгалын төлөв байдлыг урьдчилан тодорхойлж гаргасан мэдээллийг;
	4.1.16. "цаг агаарт зориудаар нөлөөлөх" гэж шинжлэх ухаан, технологийн шийдлээр агаар мандлын процессод зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг;
	4.1.17 "станц" гэж ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн байгууллагын бүтцийн нэгжийг;
	4.1.18. "ажиглалтын станц " гэж ажиглалт, хэмжилт хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж, байгууламж, талбайн цогцыг;
	4.1.19. "шинжилгээний талбай" гэж ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх зориулалтаар сонгон авч төхөөрөмжилсөн, хашаалсан болон өөр бусад байдлаар тэмдэглэж, заагласан орон зайг;
	4.1.20. "уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хувилбар" гэж нийгэм-эдийн засгийн үйл ажиллагаа, хүлэмжийн хийн ялгарал, уур амьсгалын өөрчлөлт, далайн түвшний өсөлтийн хоорондын харилцан хамаарал дээр үндэслэсэн уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагын талаарх шинжлэх ухааны үндэслэлтэй таамаглалыг;

	4.1.21. “уур амьсгалын стандарт норм” гэж ус цаг уурын үзүүлэлтүүдийн гучин жилийн дундаж утгыг;
	4.1.22. “Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ” гэж аюул, өртөмхий байдал, эмзэг байдлын мэдээлэлд үндэслэн ус цаг уур, орчны аюулын нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан таамаглаж, авах арга хэмжээний зөвлөмжийг агуулсан мэдээг;
	5 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний зарчим 5.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана: 5.1.1. тасралтгүй, тогтвортой байх; 5.1.2. шинжлэх ухааны үндэслэлтэй байх; 5.1.3. хэмжлийн нэгдмэл байдлыг хангах; 5.1.4. газар нутгийн өвөрмөгц байдлыг илэрхийлж чадахуйц байх; 5.1.5. үнэн зөв, ил тод, хүртээмжтэй байх; 5.1.6. мэдээлэл солилцооны уялдаа, нийцлийг хангасан байх;
ГУРАВДУГААР БҮЛЭГ	ХОЁРДУГААР БҮЛЭГ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ УЛСЫН СҮЛЖЭЭ, ТӨЛӨВЛӨЛТ УДИРДЛАГА
9 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ	6 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ
9.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ /цаашид "улсын сүлжээ" гэх/ нь нэгдмэл арга зүй, хөтөлбөрөөр ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажил гүйцэтгэх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус цаг уур, орчны мэдээллээр хангах үүрэг бүхий байнгын тасралтгүй ажиллагаатай өртөө, харуул, хүрээлэн, төв, лаборатори зэргээс бүрдэнэ.	6.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээ /цаашид “улсын сүлжээ” гэх/ нь ус, цаг уур, орчны төлөв байдлыг ажиглах, хэмжих, мэдээллээр хангах зорилго бүхий ажиглалтын станц, лаборатори, ажиглалт, хэмжилтийн цэгүүдээс бүрдэнэ.
	6.2. Улсын сүлжээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангана.
9.2.Улсын сүлжээний өртөө, харуулын байршил, нягтралыг үнэн зөв мэдээ гаргах шалгуурыг харгалзан, олон улсын жишигт	

нийцүүлэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтооно.	
	6.3. Уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээний ажлыг улсын сүлжээг ашиглан гүйцэтгэнэ.
9.3.Улсын сүлжээний өртөө, харуул нь төрийн өмч байна.	
9.4.Улсын сүлжээний өртөө харуулыг байгуулах, төхөөрөмжлөх, татан буулгах, багаж хэрэгслээр хангах зардал болон ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	<u>6.4 Улсын сүлжээний үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.</u>
	6.5 Төрөөс ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын үйлчилгээний инновац, судалгаа, дэвшилтэт технологи хөгжүүлэх үйл ажиллагаа болон хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.
	7 дугаар зүйл.Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөө
	7.1.Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.
	7.2.Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:
	7.2.1. Ус, цаг агаар, орчны аюултай болон онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад шаардлагатай ус цаг уур, орчны мэдээллийн хэрэгцээ;
	7.2.2. өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ;
	7.2.3. ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх үзүүлэлтүүд, орон зай, цаг хугацааны өөрчлөлт;
	7.2.4. улсын сүлжээн дэх станцын нягтрал, тоо хэмжээ, ангилал, байршил, төлөвлөлтийн зураг, станцын жагсаалт, станц тус бүрийн ажиглалтын хөтөлбөр;
	7.2.5. төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөц, арга хэмжээ, үе шат
	7.2.6 уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ, үнэлгээ;

	7.3. Улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөг 10 жилийн хугацаагаар батлах бөгөөд шаардлагатай тохиолдолд шинэчилж болно.
9.5. Аж ахуйн тодорхой хэрэгцээ, эрдэм шинжилгээний болон бусад байгууллагын захиалгын дагуу шинжилгээний өртөө, харуул байгуулах шаардлага гарвал түүнийг байгуулах, ажиллуулах асуудлыг төрийн захиргааны байгууллага нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.	
9.6. Улсын сүлжээний өртөө, харуулыг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр татан буулгах, нүүлгэн шилжүүлэхийг хориглоно.	
	8 дугаар зүйл. Улсын сүлжээний ажиглалтын станц
	8.1. Улсын сүлжээний ажиглалтын станц бүр ажиглалт, хэмжилтийн хөтөлбөртэй байна. Ижил төрлийн станц нэг хөтөлбөрөөр ажиллана.
	8.2. Улсын сүлжээний станц нь дараах төрөлтэй байна:
	8.2.1. цаг уурын
	8.2.2. ус судлалын;
	8.2.3. орчны хяналт шинжилгээний
	8.2.4 хөдөө аж ахуйн цаг уурын;
	8.2.5. дээд агаар мандлын;
	8.2.6 цаг уурын радарын;
	8.2.7 мал аж ахуйн цаг уурын;
	8.2.8 нарны цацраг судлалын;
	8.2.9. тусгай зориулалтын бусад;
	8.3. Улсын сүлжээний ажиглалтын станцыг ерөнхий төлөвлөгөөний дагуу байгуулна.
	8.4. Улсын сүлжээнд хамаарах станц, ажиглалт, хэмжилтийн цэг нь төрийн өмч байна.
	8.5. Улсын сүлжээнд хамаарах станцыг доор дурдсанаас бусад тохиолдолд нүүлгэн шилжүүлэхийг хориглоно:
	8.5.1. гамшгийн улмаас ашиглах боломжгүй болсон;
	8.5.2. батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлын шаардлага үүссэн;
	8.5.3. байгалийн нөхцөлөөс шалтгаалан ажиглалт, хэмжилтийн шаардлага хангах боломжгүй болсон.

	8.5.4 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээлэл, өгөгдөл нь орчныг төлөөлөх чадваргүй болсон
	8.6. Станцыг улсын сүлжээний ерөнхий төлөвлөгөөнөөс хассан буюу ажиглалт хийх техникийн нөхцөлийг хангахгүй болсон, эсхүл нүүлгэн шилжүүлэх боломжгүй болсон тохиолдолд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр зогсооно. Станцын байршлыг өөрчлөх бол шинэ хуучин байрлал дээр нь 3-аас доошгүй жил зэрэгцсэн хэмжилт хийнэ.
	8.7. Улсын сүлжээний станц нь хүний нөөц, хэмжих хэрэгслийн тоо хэмжээ, хөтөлбөр, үйл ажиллагааны хүрээ зэргээс хамааран зэрэглэлтэй байх бөгөөд зэрэглэлийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.
10 дугаар зүйл.Ус цаг уур, орчны шинжилгээ	9 дүгээр зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ
	9.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээг батлагдсан үндэсний стандарт, арга зүй, техникийн зааврын дагуу тасралтгүй, үнэн зөв явуулна.
10.1.Улсын сүлжээний өртөө, харуулуудад ус цаг уур, орчны шинжилгээг нэгдмэл арга зүй, хөтөлбөрийг баримтлан тусгайлан сонгож авсан талбай дээр тогтоосон хугацаанд мэргэжлийн ажилтан гүйцэтгэнэ.	
	9.2.Хяналт шинжилгээний үр дүн нь тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг бодитой, үнэн зөв илэрхийлсэн байна.
10.2.Өртөө, харуулд хийсэн шинжилгээний дүнг төрийн захиргааны байгууллагаас тогтоосон хяналтын хугацаанд дамжуулна.	
	9.3.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээг дэвшилтэт техник, технологи, инновацод тулгуурлан явуулна.
10.3.Эрдэм шинжилгээ, сургалтын зорилгоор түр хугацаагаар ажиллуулах шинжилгээний өртөө, харуулд энэ хуулийн 10.1, 10.2-т заасан нь хамаарахгүй.	
	9.5.Автоматжуулсан багаж, систем, дижитал болон зайнаас тандах технологи, хиймэл оюун ухаанд

	суурилсан арга, аргачлалыг нэвтрүүлэх, нутагшуулах замаар хүний оролцооны алдааг бууруулах, өгөгдлийн чанар, хүртээмжийг сайжруулах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор олон улсын стандарт болон сүлжээтэй нийцүүлэн хөгжүүлнэ.
10.4.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар ус цаг уур, орчны шинжилгээний ажлыг гэрээгээр хийлгэж болно.	
10.5.Монгол Улсын иргэний агаарын тээврийн хөлгийн баг нислэгийн үед нислэгийн замын дагуух цаг уурын байдлыг тодорхойлж ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагад дамжуулна.	
10.6.Агаарын хөлгөөс цаг уурын мэдээ дамжуулах журмыг төрийн захиргааны байгууллага, иргэний агаарын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран тогтооно.	
11 дүгээр зүйл.Шинжилгээний талбай	10 дугаар зүйл.Шинжилгээний талбай
11.1.Ус цаг уур, орчны шинжилгээ хийхэд зориулсан талбай нь тусгайлан сонгон авч төхөөрөмжилсөн, хашаалсан буюу өөр бусад байдлаар тэмдэглэж заагласан байна.	<u>10.1. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилт хийх шинжилгээний талбай нь тусгайлан сонгон авч, төхөөрөмжилсөн, заагласан газар байна.</u>
11.2.Шинжилгээний талбайн орчноо төлөөлөх чадварыг хадгалах зорилгоор уг талбайн байршлыг суурин газрын хэтийн төлөвлөгөөнд тусгасан байна.	
11.3.Шинжилгээний талбайгаас гадагш 100 метрийн дотор хамгаалалтын бүс тогтоож, уг бүсэд хэмжилт, шинжилгээ хийхэд саад учруулахуйц барилга барих, мод тарих, зам гаргах зэрэг үйл ажиллагааг хязгаарлана.	10.2 Шинжилгээний талбайн орчноо төлөөлөх чадварыг хамгаалах зорилгоор уг талбайгаас гадагш 100 метрийн дотор хамгаалалтын бүс тогтооно.
	10.3 Уг талбай, хамгаалалтын бүс нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарна.
	10.4. Шинжилгээний талбай нь олон улсын болон үндэсний стандарт, технологийн зааврыг хангасан байна.

	10.5.Шинжилгээний талбайд ажиглалт, хэмжилтэд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
11.4.Шинжилгээний талбайд зориулалтын бус багаж төхөөрөмж, бусад зүйл байрлуулахыг хориглоно.	<u>10.6. Хамгаалалтын бүсэд ажиглалт, хэмжилтийн үр дүнд сөргөөр нөлөөлөх барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</u>
	10.7. Төрийн болон хувийн эзэмшлийн газар, барилга байгууламжийг шинжилгээний ажиглалт, хэмжилт хийхэд ашиглаж болно.
11.5.Шинжилгээний талбайд хүрэх зам нь газар эзэмшигч, ашиглагчийн мэдлийн газраар хаагдаж байвал шинжилгээний талбайд нэвтрэх асуудлыг Газрын тухай хуулиар зохицуулна.	
11.6.Суурин газрын бичил уур амьсгал, орчны шинжилгээний ажилд энэ хуулийн 11.3-т заасан нь хамаарахгүй.	
11.7.Шинжилгээний талбайн эзэмшлийн асуудлыг Газрын тухай хуулиар зохицуулна.	
12 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах	
12.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд стандарт, техникийн шаардлага хангасан хэмжих хэрэгсэл, шинжилгээний арга ашиглана.	
12.2.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд ашиглах хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажлыг зохих журмын дагуу эрх авсан мэргэжлийн байгууллага гүйцэтгэж баталгаажуулна.	
12.3.Баталгаажуулаагүй хэмжих хэрэгслээр хийсэн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний дүнг албан ёсны мэдээлэлд ашиглахыг хориглоно.	
12.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажил, ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах, аюулт үзэгдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээний хангалт, ашиглалтын талаар дагаж мөрдүүлэхээр гаргасан хууль тогтоомж, журам, зааврын	

биелэлтэд улсын байцаагч хяналт тавина.	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	ГУРАВДУГААР БҮЛЭГ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ	УС, ЦАГ УУР, ОРЧНЫ БОДИТ БОЛОН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ, СЭРЭМЖЛҮҮЛЭГ
	11 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн ангилал, төрөл, хугацаа, үнэлгээ
	11.1.Ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг дараах ангилалтай байна:
	11.1.1.нийтийн хэрэгцээний мэдээ;
	11.1.2.тусгай хэрэгцээний мэдээ.
	11.2. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ дараах төрөлтэй байна:
	11.2.1. ус, цаг агаар, орчны урьдчилсан мэдээ;
	11.2.2. ус, цаг агаар, уур амьсгал, орчны урьдчилсан төлөв;
	11.2.3. ус, цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг;
	11.2.4 хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээ;
	11.3 Ус цаг уур, орчны сэрэмжлүүлэг нь дараах төрөлтэй байна:
	11.3.1.анхааруулах мэдээ;
	11.3.2 сэрэмжлүүлэх мэдээ;
	11.3.3.урьдчилан сэргийлэх мэдээ.
	11.4.Энэ хуулийн 11.3.1-т заасан анхааруулах мэдээний төрөл, хамаарах цаг агаарын үзэгдлийн жагсаалтыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
	11.5. Энэ хуулийн 11.3.2,11.3.3-т заасан мэдээний төрөлд хамаарах ус цаг уурын гаралтай аюултай болон онц аюултай үзэгдлийн жагсаалтыг Засгийн газар батална.
	11.6. Хөдөө аж ахуй болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй ус цаг уурын гаралтай үзэгдлийг хор хөнөөлийнх нь байдлаар аюултай болон онц аюултай үзэгдэл гэж ангилна.
	11.7.Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэх мэдээний хугацаа:
	11.7.1. хэт богино хугацаа;
	11.7.2. богино хугацаа;

	11.7.3. дунд хугацаа;
	11.7.4. урт хугацаа;
	11.7.5. бусад хугацаа.
	11.8. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг нь нийгэм эдийн засгийн салбар, хүн ам, эд хөрөнгөд үзүүлэх нөлөөллийг тусгаж, нөлөөлөлд суурилсан урьдчилан мэдээ болон сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг агуулсан байж болно.
	12 дугаар зүйл. Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах
	12.1. Ус цаг уурын урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг болон орчны чанарын талаарх мэдээллийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.
	12.2. Урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг гаргах үйл ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна:
	12.2.1. мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ
	хийх;
	12.2.2. урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг боловсруулах;
	12.2.3. хэрэглэгчийг мэдээллээр хангах;
	12.2.4. урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийн чанарын үнэлгээ хийх;
	12.3 Ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг гаргасан байгууллага онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Үндэсний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны байгууллага, иргэдэд хүргэнэ.
	12.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны баталгаажуулаагүй урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэгийг олон нийтэд түгээхийг хориглоно.
13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээлэл дамжуулах	13 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээ дамжуулах
13.1. Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг харилцаа холбооны байгууллага хяналтын хугацаанд саадгүй дамжуулна.	13.1. Энэ хуулийн 14.1-д заасан мэдээг харилцаа холбооны байгууллага тогтоосон хяналтын хугацаанд саадгүй дамжуулна.
13.2. Улсын сүлжээний өртөө, харуулын мэдээг нэгтгэж олон улсын цаг уурын харилцаа холбооны сүлжээнд оруулах, уг сүлжээнээс Монгол Улсад	13.2 Энэ хуулийн 14.1-д заасан мэдээг нэгтгэж олон улсын цаг уурын харилцаа холбооны сүлжээнд оруулах, уг сүлжээнээс Монгол Улсад шаардагдах мэдээллийг хүлээн авахад дотоодын болон олон улсын холбооны

шаардагдах мэдээллийг хүлээн авахад дотоодын болон олон улсын холбооны суваг ашиглана. Уг сувгаар газар хөдлөл, химийн болон цөмийн осол, иргэний агаарын тээврийн нислэгт зориулсан цаг уурын мэдээ зэрэг бусад шуурхай мэдээг дамжуулж болно.	суваг ашиглана. Уг сувгаар газар хөдлөл, химийн болон цөмийн осол, иргэний агаарын тээврийн нислэгт зориулсан цаг уурын мэдээ зэрэг бусад шуурхай мэдээг дамжуулж болно.
	13.3. Ус цаг агаар, орчны аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр эхний ээлжид шуурхай дамжуулна.
13.3. Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай ус цаг уур, орчны шинжилгээний аль ч байгууллагад яаралтай мэдээлэх үүрэгтэй. Ийнхүү мэдээлэхтэй холбогдсон зардлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон үнэлгээний дагуу иргэнд нөхөн олгож болно.	13.4. Иргэд хүн ам, байгаль орчинд ноцтой нөлөөлөх аюулт үзэгдэл, гамшиг тохиолдсон буюу тохиолдох нөхцөл бүрдсэн тухай ус цаг уур, орчны хяналт шинжилгээний аль ч байгууллагад яаралтай мэдээлэх үүрэгтэй. Ийнхүү мэдээлэхтэй холбогдсон зардлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон үнэлгээний дагуу иргэнд нөхөн олгож болно.
13.4. Аюулт үзэгдэл, гамшгийн тухай мэдээллийг харилцаа холбооны бүх төрлийн хэрэгслээр өмчийн ялгаа харгалзахгүйгээр эхний ээлжинд шуурхай дамжуулна.	13.5. <u>Гэнэтийн аюул, үйлдвэрлэлийн ослын үед</u> нийтэд мэдээлэх орчны ноцтой бохирдлын сэрэмжлүүлэх мэдээний жагсаалтыг Засгийн газар батална.
	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, АРХИВ
	14 дүгээр зүйл. Ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн нэгдсэн сан
	14.1. <u>Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбар нь мэдээ, мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд уг сан нь төрийн өмч байна.</u>
	14.2. Нэгдсэн сан нь дараах ус, цаг агаар, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллээс бүрдэнэ.
	14.2.1. Ус, цаг агаар, уур амьсгал, орчны ажиглалт, хэмжилтийн мэдээ, баримт;
	14.2.2 гадаад улс, олон улсын байгууллагаас хүлээн авсан мэдээ, баримт;

	14.2.3 хиймэл дагуулын мэдээнд суурилсан ой, хээрийн түймэр, ургамалжилт, цасан бүрхүүл, хөрсний сэдэвчилсэн зураглал
	14.2.4 ус цаг уур, орчны бодит болон урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, төлөв байдлын тойм;
	14.2.5. ус цаг уур, орчны станц, хэмжих хэрэгслийн техникийн бүртгэл
	14.2.6. ус цаг уур, орчны шинжлэх ухааны судалгаа, төсөл хөтөлбөрийн үр дүн;
	14.2.7. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа, үр дүн;
	14.2.8. техникийн заавар, үйл ажиллагааны журам.
	14.2.9. Байгаль орчны төлөв байдлын тайлан
	14.2.10. Озон, хүлэмжийн хий, мал аж ахуй, газар бүрхэвчийн салбарын хүлэмжийн хийнүүдийн ялгаралт, озон задалдаг бодисуудын тоо бүртгэл
	14.2.11. Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлттэй холбогдох хүлэмжийн хийн шингээлт
	14.3. Нэгдсэн сангийн үйл ажиллагаа, бүрдүүлэлт, ашиглах асуудлыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.
	14.4. Нэгдсэн сангийн өгөгдөл, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах, кибер аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.
15 дугаар зүйл. Ус цаг уур, орчны мэдээллээр хэрэглэгчийг хангах	
15.1. Урьдчилсан мэдээ, аюулт үзэгдэл, гамшгийн тухай урьдчилан сэргийлэх мэдээг аймаг, бүс нутаг, улс орны хэмжээнд нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээнэ.	
15.2. Урьдчилан сэргийлэх мэдээг радио, телевиз болон мэдээллийн бусад хэрэгслээр түүнийг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлнэ.	
15.3. Тусгай хэрэгцээний мэдээг тухайн хэрэглэгчийн шаардлагын	

дагуу уг хэрэглэгчтэй хийсэн гэрээний дагуу гаргаж өгнө.	
15.4.Даатгалын байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад даатгалын төлбөр олгохдоо тухайн үеийн ус цаг уур, орчны нөхцөл байдлын тухай ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагаас гаргасан тодорхойлолтыг үндэслэн олгоно.	
15.5.Зураг төслийн болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажилд зөвхөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэргэжлийн байгууллагаас тогтоосон журмын дагуу шалгаж баталгаажуулсан мэдээллийг ашиглана.	
	15 дугаар зүйл. Мэдээ, мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, хэрэглээ
	15.1. Хэрэглэгч нэгдсэн сан, архивын мэдээллийг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу ашиглаж болно.
	15.2. Хэрэглэгчийн ашиглаж буй ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийн эх сурвалж нь тодорхой байх бөгөөд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаажуулсан байна.
	15.3. Нэгдсэн сан, архивын баримтаас лавлагаа, мэдээлэл авахад үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний хөлсийг хуулиар эрх олгосон байгууллага батална.
	15.4. Энэ хуулийн 15.3-д заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн үйлчилгээний хөлсний таваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг төрөлжсөн архивын баримтын цахимжуулалт, мэдээллийн технологийн шинэчлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, сургалт зохион байгуулах ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.
	15.5. Даатгалын байгууллага шаардлагатай тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад даатгалын төлбөр олгохдоо тухайн үеийн ус цаг уур, орчны нөхцөл байдлын тухай ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагын тодорхойлолтыг үндэслэн олгоно.

14 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны мэдээллийн архив, сан	16 дугаар зүйл. Ус цаг уур, уур амьсгал, орчны хяналт шинжилгээний төрөлжсөн архив
14.1. Ус цаг уур, орчны мэдээллийн архив нь төрөлжсөн архив байна.	16.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрөлжсөн архив нь ус цаг уур, орчны хяналтын чиглэлээр хийгдсэн шинжилгээ судалгааны эх болон боловсруулсан мэдээ баримтыг хадгалж хамгаалах, зүй зохистой ашиглах байнгын үйл ажиллагааг явуулна.
	16.2. Ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг байнга хадгалж, архивлана.
	16.3. Ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийн эх баримтын хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг төрийн захиргааны байгууллага түүний харьяа байгууллага хүлээнэ.
14.2. Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээ баримтыг архивт шилжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх журмыг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.	16.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрөлжсөн архивын баримтыг цахим хэлбэрээр бүрдүүлэх, хөгжүүлэх боломжтой байна.
	ТАВДУГААР БҮЛЭГ
	ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ БАЙДАЛД ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
	17 дүгээр зүйл. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа
	17.1. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг тодорхой бүс нутагт, тодорхой хугацаанд дараах зорилгоор явуулж болно.
	17.1.1. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
	17.1.2. Аадар бороо, мөндөр зэрэг хур тунадасны эрчмийг
	бууруулах, түүнээс урьдчилан сэрэмжлүүлэх;
	17.1.3. Манан сарниулах;
	17.2. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, шинэ техник технологи нэвтрүүлэх ажлыг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэнэ.
	17.3. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа нь агаар мандлын төлөв байдал, уур амьсгалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх

	бөгөөд нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа, улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдалд саад учруулахгүй байвал зохино.
	17.4. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ашиглах техник, технологи, урвалж бодис зэрэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй байх шаардлагыг хангасан байна.
	17.5. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад нисэхийн аюулгүй байдал, бусад холбогдох байгууллагатай уялдуулан зохион байгуулна.
	17.6. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны явц, үр дүнд ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний байгууллага хяналт-шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг түр зогсоох, өөрчлөх санал гаргана.
	17.7. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар холбогдох байгууллагад тайлагнана.
	17.8. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг байгаль орчин, нийгэм-эдийн засгийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, тодорхой салбарын үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой бүс нутагт, тодорхой хугацаанд эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хэрэгжүүлж болно.
	17.9. Цаг агаарын төлөв байдалд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах тохиолдолд тухай бүрд холбогдох байгууллагад мэдэгдэн, олон нийтэд мэдээлнэ.
ХОЁРДУГААР БҮЛЭГ	ЗУРГААДУГААР БҮЛЭГ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ, ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ	УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТӨРИЙН БОЛОН
	НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ
	18 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх
	18.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

	18.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
	18.1.2. энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;
	18.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.
4 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх	19 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх
4.1.Засгийн газар нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	19.1.Засгийн газар ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
4.1.1.ус цаг уур, орчны мэдээлэл, уур амьсгалын нөөцийг нийгэм, эдийн засгийн хөгжилд бүрэн дүүрэн ашиглах нөхцөлийг хангах;	19.1.1.ус цаг уур, орчны мэдээлэл, уур амьсгалын нөөцийг нийгэм, эдийн засгийн хөгжилд бүрэн ашиглах;
4.1.2. ус цаг уур, орчны мэдээллийг ашиглах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх;	19.1.2.ус цаг уур, орчны мэдээллийг ашиглах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх;
<u>/Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u>	19.1.3.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагаанд шаардагдах төсвийн төслийг боловсруулж батлуулах;
	19.1.4.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх дүрэм, журмыг батлах;
4.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.	19.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.
5 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	20 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
5.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь / цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	20.1.Төрийн захиргааны төв байгууллага ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
5.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх төрийн бодлого боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих;	20.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх төрийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;
	20.1.2.тусгай хэрэгцээний мэдээний төрөл, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах;
5.1.2.ус цаг уур, орчны мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчид мэдээлэх улсын сүлжээг зохион	

байгуулан түүний хөтөлбөрийг батлах;	
5.1.3.тусгай хэрэгцээний мэдээний нэр төрөл, үйлчилгээний үнэ тарифийг батлах, урьдчилан сэргийлэх мэдээ болон нийтийн хэрэгцээний мэдээг радио, телевиз, мэдээллийн бусад хэрэгслээр дамжуулах, түгээх журмыг холбогдох байгууллагатай хамтран тогтоох;	
5.1.4.цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд хяналт тавих.	20.1.3.агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хяналт тавих.
	20.1.4.ус цаг уур, орчны ажиглалт, хэмжилтийн хөтөлбөрийг станцын төрөл тус бүрээр тогтоох;
	20.1.5 хуульд заасан бусад бүрэн эрх.
	21 дүгээр зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх, үүрэг
	21.1 Аймаг нийслэл, сум дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй
	21.1.1 Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний станц, шинжилгээний
	талбай, хамгаалалтын бүсийн газрын асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх, хяналт тавих,
	21.1.2 Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэвийн, тасралтгүй,
	байнгын үйл ажиллагааг дэмжиж, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтанд шаардагдах төсвийг батлах хэрэгжилтэнд хяналт тавих;
	21.1.3 Орон нутгийн онцлог, байгаль ус цаг уур, орчны аюултай үзэгдлээс эрт сэрэмжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
7 дугаар зүйл.Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хорооны Засаг даргын эрх, үүрэг	22 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг
7.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй:	22.1. Аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй:
7.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх хууль тогтоомж, Засгийн газар, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах;	22.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаарх хууль тогтоомж, Засгийн газар, бусад эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах;

7.1.2.нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагааны нэгдмэл дэг журмыг мөрдүүлэх;	22.1.2.нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний станцын тасралтгүй, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
7.1.3. ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай хангах, аюул болон орчны ноцтой бохирдлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах;	22.1.3.ус цаг уур, орчны мэдээллээр нутаг дэвсгэрийнхээ хэрэглэгчийг шуурхай хангах, ус цаг уурын гаралтай аюултай үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах;
	22.1.4.нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талбай, тоног төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээ авах.
7.1.4. нутаг дэвсгэртээ аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг тооцож, хохирлоос урьдчилан сэргийлэх журамд тодотгол хийж байх, учирсан хохирлын талаар төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх;	22.1.5 нутаг дэвсгэртээ аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг тооцож, хохирлоос урьдчилан сэргийлэх журамд тодотгол хийж байх, учирсан хохирлын талаар төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх;
<u>7.1.5./Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/</u>	
7.2.Баг, хорооны Засаг дарга ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах эрх, үүрэгтэй:	
7.2.1.энэ хуулийн 7.1.3-т заасан бүрэн эрхийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх;	
7.2.2. аюулт үзэгдэл, гамшгийн хохирлыг тооцож сум, дүүргийн Засаг даргад шуурхай мэдээлэх;	
7.2.3.нутаг дэвсгэрийнхээ ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талбай, тоног төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээ авах.	
	ДОЛООДУГААР БҮЛЭГ
	УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТОГТОЛЦОО
	23 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо
	23.1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл /сум, дүүрэг/-ийн ус цаг уур, орчны

	хяналт шинжилгээний газар, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, байгаль орчны лаборатори, хэмжил зүйн лаборатори, нислэгийн цаг уурын, зайнаас тандах судлалын, цаг уурын харилцаа холбоо мэдээллийн төвүүдээс бүрдэнэ.
	Хүрээлэн, лабораторийн чиг үүрэг байхгүй
	23.2. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний алба нь өөрийн харьяанд эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл болон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хийх үүрэг бүхий мэргэжлийн нэгж/төв/-тэй байна.
	23.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний алба нь мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.
	23.4. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 ⁴ .2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.
	23.5. Энэ хуулийн 23.1-д заасан албадын удирдлага /дарга,захирал/-ыг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, ажилтанг тухайн байгууллагын удирдлага Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.
	23.6. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны төсвийг улсын төсөвт тусган санхүүжүүлнэ.
6 дугаар зүйл.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх	24 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
6.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	24.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үндсэн чиг үүрэгтэй:
	24.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
	24.1.2.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах;
6.1.2. ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай үйлчлэх, аюулт үзэгдэл, гамшиг, орчны	

бохирдлоос сэрэмжлүүлэх арга хэмжээ авах;	
<u>/Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u>	24.1.3. ус цаг уурын ажиглалт, хэмжилт, дүн шинжилгээ, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ хийх;
6.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сүлжээний нэгжийг байгуулах, татан буулгах, шилжүүлэх;	24.1.4 улсын сүлжээний станцыг байгуулах, татан буулгах, нүүлгэн шилжүүлэх, үйл ажиллагааг зогсоох
6.1.3.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартчиллыг хангах;	24.1.5 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартчиллыг хангах;
6.1.4.шаардлагатай тохиолдолд цаг агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд нөлөөлөх ажиллагаа явуулах;	
	24.1.6 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний судалгаа, шинжилгээний ажил хийх
6.1.5.ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийг цуглуулах, солилцоонд гаргахад олон улсын мэдээллийн суваг ашиглах асуудлыг зохицуулах, Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх;	;
	24.1.7.хэрэглэгчийг ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллээр шуурхай хангах;
	24.1.7.шаардлагатай тохиолдолд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг гүйцэтгэх;
6.1.7.ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг зохицуулах.	
6.2.Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг тухайн шатны Засаг даргатай нь зөвшилцөн мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллагын дарга томилж, чөлөөлнө.	
	24.1.7. ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон дүрэм, журам, аргачлал, зааварыг батлах;

6.1.6.ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;	24.1.8. ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;
	24.1.9. ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг зохион байгуулах;
	24.1.10. уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа шинжилгээ, нөлөөллийн болон эрсдэлийн үнэлгээг шинжлэх ухааны байгууллага, их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;
	24.1.11. салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
	24.1.12.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээллийг цуглуулах, гадаад солилцоонд гаргахад олон улсын мэдээллийн суваг ашиглах асуудлыг зохицуулах, 24.1.12.Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх;
	24.1.13.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааны талаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.
	24.2.Энэ хуулийн 24.2-т заасан харьяа байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаар, дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
6.2.Аймаг, нийслэлийн ус цаг уур, орчны шинжилгээний төв болон лаборатори, хүрээлэнгийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн харьяалах төв, лаборатори, хүрээлэнгийн дарга томилж, чөлөөлнө.	

	24 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
	24.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үндсэн чиг үүрэгтэй:
	24.1.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
	24.1.2.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг удирдан зохион байгуулах;
	24.1.3. ус цаг уурын ажиглалт, хэмжилт, дүн шинжилгээ, орчны хяналт шинжилгээ, уур амьсгалын өөрчлөлтийн хяналт шинжилгээ хийх;
	24.1.4 улсын сүлжээний станцыг байгуулах, татан буулгах, нүүлгэн шилжүүлэх, үйл ажиллагааг зогсоох
	24.1.5 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдал, мэдээллийн стандартчиллыг хангах;
	24.1.6 ус цаг уур, орчны хяналт шинжилгээний судалгаа, шинжилгээний ажил хийх;
	24.1.7.хэрэглэгчийг ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллээр шуурхай хангах;
	24.1.7.шаардлагатай тохиолдолд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг гүйцэтгэх;
	24.1.7. ус цаг уур, орчны хяналт шинжилгээтэй холбогдсон дүрэм, журам, аргачлал, зааварыг батлах;
	24.1.8. ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах;
	24.1.9. ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд орчин үеийн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг зохион байгуулах;
	24.1.10. уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа шинжилгээ, нөлөөллийн болон эрсдэлийн үнэлгээг шинжлэх ухааны байгууллага, их сургуулиудын дэргэдэх эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;
	24.1.11. салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
	24.1.12.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээллийг цуглуулах, гадаад солилцоонд

	гаргахад олон улсын мэдээллийн суваг ашиглах асуудлыг зохицуулах, 24.1.12.Дэлхийн цаг уурын байгууллагын конвенцийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх;
	24.1.13.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний үйл ажиллагааны талаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх.
	24.2.Энэ хуулийн 24.2-т заасан харьяа байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаар, дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
	25 дугаар зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа
	25.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах эрхтэй:
	25.1.1.эрүүл, аюулгүй, стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;
	25.1.2.гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран тусгай зориулалтын хувцас, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдах;
	25.1.3. хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах;
	25.1.4.хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;
	25.1.5.хуульд заасан бусад.
	25.2.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах үүрэгтэй:
	25.2.1.ус цаг уур, орчны ажиглалт хэмжилтийг техникийн заавар, хөтөлбөрийн дагуу үнэн зөв, байнга, тогтмол, тасралтгүй хийж, үр дүнг шуурхай мэдээлэх;
	25.2.2.холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, аргачлалыг чанд сахин мөрдөх;
	25.2.3.мэргэжлийн ёс зүйг чандлан сахих,
	25.2.4.улс төрөөс ангид байж, хуулиар зөвшөөрснөөс бусад улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх;
	25.2.5.мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;
	25.2.6.хуульд заасан бусад.
	25.3. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны ажилтан дараах нийгмийн баталгаагаар хангагдана:

	25.3.1. Ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох;
	25.3.2. Салбартаа тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд тав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгох, түүнийг олгохтой холбоотой журмыг Засгийн газар батална.
	25.3.3. Ус цаг агаар, орчны онц аюултай үзэгдэлтэй үед ажилласан ажилтанд ажилласан хугацааны цалин хөлсийг нь гурав дахин нэмэгдүүлж олгох;
	25.3.4. албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд таван жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн ажилтны сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгох;
	25.3.5. хөдөлмөрийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтанд мөнгөн урамшуулал олгох;
	25.3.6. амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэх тохиолдолд мөнгөн урамшуулал олгох;
	25.3.7.гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал хамрагдах .
	25.4.Энэ хуулийн 25.3.5, 25.3.6-д заасан мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
	25.5. Ажилтан албан үүргээ зохих журмын дагуу биелүүлэх явцдаа бусдын эд хөрөнгөд хохирол учруулсан бол тухайн хохирлыг төр хариуцна.
	25.6.Энэ хуулийн 26.3-т заасан нийгмийн баталгааг олгоход шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
	НАЙМДУГААР БҮЛЭГ
	УС ЦАГ УУР, ОРЧНЫ ҮЙЛЧИЛГЭЭ
	26 дугаар зүйл.Ус цаг уур, орчны үйлчилгээ
	26.1.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах үйлчилгээг үзүүлнэ:
	26.1.1.нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах;
	26.1.2.тусгай хэрэгцээний мэдээгээр хангах;

	26.1.3. агаарын төлөв байдал, цаг агаарт зориудаар нөлөөлөх;
	26.1.4. нислэгийн цаг уурын үйлчилгээ;
	26.1.5. хэмжилт, ажиглалтын багаж хэрэгслийг баталгаажуулах;
	26.1.6 Орчны чанарын хяналт шинжилгээ үйлчилгээ;
	26.1.7 Уур амьсгалын мэдээллийн үйлчилгээ;
	26.1.8 Хөдөө аж ахуйн цаг уурын үйлчилгээ;
	26.2. Энэ хуулийн 27.1.1-т заасан нийтийн хэрэгцээний мэдээгээр хэрэглэгчийг хангах үйлчилгээг үндсэн чиг үүргийн хүрээнд үнэ төлбөргүй үзүүлнэ.
	26.3. Энэ хуулийн 26.1.2-26.1.5-д заасан үйлчилгээг хэрэглэгчийн хүсэлтэд үндэслэн төлбөртэй үзүүлнэ.
	26.4. Энэ хуулийн 26.1.2, 26.1.3, 26.1.4-д заасан үйлчилгээний төлбөрийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
	26.5 Энэ хуулийн 26.1.5-д заасан үйлчилгээний төлбөрийн хэмжээг холбогдох хуулиар эрх олгосон Засгийн газрын гишүүн батална.
	26.6. Нислэгийн цаг уурын үйлчилгээг Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц, Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Дэлхийн цаг уурын байгууллагын гаргасан баримт бичигт нийцсэн нисэхийн цаг уурын үйл ажиллагааны стандарт, шаардлага хангасан дүрэм, заавар, журмын дагуу үзүүлнэ.
	26.7. Монгол Улсын иргэний агаарын тээврийн хөлгийн баг нислэгийн үед нислэгийн замын дагуух цаг уурын байдлыг тодорхойлж ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагад дамжуулна.
	26.8. Агаарын хөлгөөс цаг уурын мэдээ дамжуулах журмыг Дэлхийн цаг уурын байгууллага, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон заавар, журамд нийцүүлэн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, иргэний агаарын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран тогтооно.
	26.9. Энэ хуулийн 26.6-д заасан заавар, журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
8 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний мэдээллээр хангах	27 дугаар зүйл. Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ

ажлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрхлэх	
8.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч тусгай хэрэгцээний мэдээлэл гаргах үйлчилгээ эрхэлж болно.	27.1.Энэ хуульд заасан ус цаг уур, орчны үйлчилгээ, ажиглалт, хэмжилт (цаашид “хувийн ус цаг уурын үйлчилгээ” гэх)-ийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болно.
	27.2. Тусгай зөвшөөрлийг Ус цаг уурын үндэсний албаны саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 жилийн хугацаагаар олгоно.
	27.3.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг ирүүлнэ:
	27.3.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;
	27.3.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
	27.3.3.аж ахуйн нэгжийн танилцуулга;
	27.3.4.хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга;
	27.3.5.аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх тодорхойлолт;
	27.3.6.хүний нөөцийн мэдээлэл, энэ хуулийн 28.7.3-т шаардлагыг хангасан талаарх баримт;
	27.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаанд нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй, зөрчил гаргаагүй бол эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг анх олгосон хугацаагаар сунгана.
	27.5.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
	27.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаанд нөхцөл, шаардлага, үүргээ ноцтой зөрчсөн, эсхүл хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй бол тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.
8.2.Зөвшөөрлийг дараахь нөхцөлд олгоно:	27.7. Хувийн ус цаг уур, орчны үйлчилгээ үзүүлэгч дараах шаардлагыг хангана.
8.2.1.ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх тогтолцоог бүрдүүлсэн, эсхүл төв, орон нутгийн ус цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас	

хангагдахаар гэрээ байгуулсан байх;	
	27.7.1. санхүүгийн чадамжтай байх бөгөөд эх үүсвэр нь хууль ёсны байх;
	27.7.2. үйлчилгээ үзүүлэхэд ашиглах мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах;
8.2.2.мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байх.	27.7.3. холбогдох мэргэжлээр мэргэшсэн, туршлагатай хүний нөөцтэй байх.
	27.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн боловсруулсан ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээллийг энэ хуулийн 14.1-д заасан нэгдсэн санд нийлүүлнэ.
	27.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулсан багаж, тоног төхөөрөмж хэрэглэнэ. Баталгаажуулаагүй багаж, тоног төхөөрөмжийн мэдээ, мэдээллээр үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
8.3.Зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийг зөрчсөн үйл ажиллагаа явуулсан, эсхүл хэрэглэгчээс гарсан гомдол үндэслэлтэй болох нь тогтоогдвол зөвшөөрлийг хүчингүй болгож болно.	27.10.Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.
ТАВДУГААР БҮЛЭГ	ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ	БУСАД
	28 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа
	28.1. Ус цаг уурын албаны дарга нь Монгол улсаас томилогдсон Дэлхийн цаг уурын байгууллагын байнгын төлөөлөгч байна.
	28.2 Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоожид нийцүүлэн хэрэгжүүлнэ:
	28.2.1.ус цаг уур, уур амьсгал, орчны мэдээ, мэдээлэл, өгөгдөл, судалгааг олон улсын байгууллага, гадаад улстай харилцан солилцох;
	28.2.2.бүс нутгийн болон дэлхийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт оролцох, хамтран хэрэгжүүлэх;

	28.2.3.олон улсын байгууллага болон гадаад улс оронтой хамтран судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх;
	28.2.4.боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх , бэлтгэх, харилцан солилцох.
16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
16.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	29.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
16.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	29.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
17 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх	
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо ерөнхий байцаагчид гаргана. Ерөнхий байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл маргааныг шүүх шийдвэрлэнэ.	